

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ
ХЯНАЛТЫН СУУРЬ
КОНВЕНЦ

17 ба 18 дугаар зүйл
Бодлогын зөвлөмж



FCTC

WHO FRAMEWORK CONVENTION
ON TOBACCO CONTROL

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

17 ба 18 дугаар зүйл

“Тамхины үйлдвэрлэлийг орлох
амьжиргааны эх үүсвэр бүрдүүлэх
бодлогын зөвлөмж”

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/m/item/policy-options-and-recommendations-on-economically-sustainable-alternatives-to-tobacco-growing>

ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН 17 БА 18 ДУГААР ЗҮЙЛ

ТАМХИНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ОРЛОХ АМЬЖИРГААНЫ ТОГТВОРТОЙ ЭХ ҮҮСВЭР БҮРДҮҮЛЭХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

1. ТАНИЛЦУУЛГА

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (ТХСК)-д тамхины хэрэглээ, тамхины утаанд өртөхийг бууруулах нотолгоонд тулгуурласан салбар хоорондын цогц арга хэмжээг тусгасан байна. Үүний зэрэгцээ тамхины үйлдвэрлэлийг орлох амьжиргааны эх үүсвэрийг бий болгож, тамхины үйлдвэрлэлээр амьжиргаагаа залгуулдаг хүн амд тамхины хяналтын арга хэмжээний үзүүлж болох нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавраас сэргийлэхийн чухлыг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн Оролцогч талууд тамхины тариалалт, үйлдвэрлэлтэй холбоотой байгаль орчин, хүний эрүүл мэндийг хамгаалах асуудалд анхаарлаа хандуулахаар зөвшилцсөн байна.

1.1 Тамхины үйлдвэрлэлийн дэлхийн сүлжээ¹

Дэлхийн тамхины үйлдвэрлэл нь тамхи (*Nicotiana tabacum* эсхүл *Nicotiana rustica*)-ны тариалалтаас хамаардаг төрөлжсөн олигополь юм.

- Тамхины үйлдвэрлэлийн хөдөө аж ахуй (ХАА)-н салбарт **тамхи тариаланчид, бусад ажилчид** ажилладаг ба 2011 оны байдлаар 120 орчим улсад² 4,211,885 га талбайд³ 7,461,994 тонн тамхины түүхий эд тариалсан байна. Гэрээ байгуулах, дэмжих үйлчилгээ, маркетингийн систем зэрэгтэй холбоотой ХАА-н салбарт тулгамдаж буй асуудал нь бүс нутгаар ялгаатай байна.
- Тамхины навчны **анхдагч боловсруулалтыг** "навчны компани", "анхан шатны боловсруулагч" хэмээх мэргэшсэн компаниуд хийж гүйцэтгэдэг. Дэлхийд цөөн компани энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.⁴ 4 Эдгээр компани нь тариаланчдыг тамхи тариалахад шаардлагатай зээл, бусад орцоор хангадаг байна.
- **Тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэгчид** нь янжуур тамхи, Ороомол навчин тамхи, утаагүй тамхи (зажилдаг болон хамрын тамхи), дүнсэн тамхи, дахин биежүүлсэн тамхи, бидис зэрэг бусад тамхин бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, брэнд болгон маркетинг хийдэг.

Тамхи тариаланчдын олж буй орлого нь нэмүү өртөг шингэсэн сүлжээний⁵ эцсийн бүтээгдэхүүний үнэтэй харьцуулахад маш бага юм. Тариаланчдын ургуулж, "анхан шатны боловсруулагчид" зарсан нэг тонн тамхины түүхий эдийн

¹ Энэ хэсэгт ашигласан тоо баримтыг үе үе шинэчилнэ

² Geist HJ, Chang K, Etges V, Abdallah JM. Tobacco growers at the crossroads: Towards a comparison of diversification and ecosystem impacts. Land Use Policy. 2009;26:1066-79.

³ НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага. <http://faostat.fao.org/site/567/default.aspx#ancor>

⁴ Van Liemt G. The world tobacco industry: trends and prospects. Geneva: International Labour Office; 2002 (Sectoral Activities Programme working paper No. 179).

⁵ Тамхины олон улсын хамгийн том 5 компани. <http://www.top5ofanything.com/index.php?h=fb59add3>

үнэ үйлдвэрлэлийн сүлжээгээр дамжин хэрэглэгчийн гарт хүрэхдээ 47.2 дахин нэмэгддэг⁶ гэсэн тооцоолол байна.

1.1.1 Тамхин бүтээгдэхүүний хэрэглээний дэлхийн хандлага

Дэлхий нийтэд тамхины тахал өргөжиж, үндэстэн дамнасан тамхи үйлдвэрлэгчид маркетингийн үйл ажиллагаагаа Зүүн Европ, Ази, Африк, Латин Америк руу чиглүүлсний үр дүнд бага ба дунд орлоготой улс орнуудад төвлөрч байна.^{7,8}

Тамхичдын тоо болон тамхины хэрэглээ 20 жилийн хугацаанд аажим буурна гэсэн тооцооллыг арван жилийн өмнө хийж байсан. Өнөөдрийн байдлаар дээрх 20 жилийн тал нь өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд ДЭМБ-ын ТХСК-ийн хэрэгжилтэд ахиц дэвшил гарч, тамхины эрэлт буурах шинж тэмдэг илэрч эхлээд байна.

Иймд дэлхий нийтийн тамхины хяналтын дүр зургийг томоор харж, тамхи тариаланчдын амьжиргаа, тамхи тариалдаг бүс нутгийн эдийн засагт тамхины хяналтын үзүүлж болох үр нөлөөг сайтар ойлгох шаардлагатай байна.

Дээрх хандлагын улмаас тамхи тариалдаг бүс нутгийн Оролцогч талууд, нэн ялангуяа тамхи үндэсний эдийн засгийн орлогын чухал эх үүсвэр болдог Оролцогч талуудын зүгээс ДЭМБ-ын ТХСК-ийн 17 дугаар зүйлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах шаардлага хурцаар тавигдаж байна.^{9,10}

1.1.2 Тамхины үйлдвэрлэлийн сүлжээн дэх хөдөлмөрлөх хүчний эрэлт

Тамхины үйлдвэрлэлийн сүлжээ буюу ХАА, үйлдвэрлэл, үйлчилгээ (үүнд борлуулалт, түгээлт) гэсэн 3 салбарт хөдөлмөрлөх хүч шаардлагатай байдаг. ХАА-н салбар нь тамхи тариаланчид болон гэрээт, гэрээт бус, байнгын буюу улирлын чанартай ажилчдаас бүрддэг.

Бусад төрлийн үр тариатай харьцуулахад тамхи тариалахад нэг га-д шаардлагатай гар ажиллагаа механикжсан фермийн хувьд ч гэсэн асар их байдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын 2003 оны тайлангаас харахад тамхи үйлдвэрлэлийн салбарт 2003 оны байдлаар 100 сая хүн ажиллаж байснаас дөнгөж 1.2 сая нь үйлдвэрт, 40 сая нь тариан талбай болон "навчны компани"-д, 20 сая нь өрхийн аж ахуй (ж.нь, Энэтхэгт бидис тамхи гараар ороох үйлдвэрлэл)-д, үлдсэн 38.8 сая нь тамхины түгээлт, борлуулалт, сурталчилгааны салбарт ажиллаж байв.¹¹ Иймд бодлогын зөвлөмж боловсруулахад эдгээр хүмүүсийг бүгдийг нь тамхи үйлдвэрлэлийн салбарын ажилчид гэж үзэх шаардлагатай юм.

⁶ Тамхины зах зээл дээрх бүтээгдэхүүний үнийн дүнг тариаланчдын борлуулж буй тамхины түүхий эдийн үнэд харьцуулсан харьцаа.

⁷ Shafey O et al. The tobacco atlas, 3rd ed. Atlanta (GA): American Cancer Society and World Lung Foundation; 2009.

⁸ WHO report on the global tobacco epidemic, 2008. Geneva: World Health Organization; 2008.

⁹ Ройтерс, 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр (<http://uk.reuters.com/article/2014/04/29/brit-am-tobacco-germany-idUKL2NONE19820140429>).

¹⁰ Блүүмберг, 2014 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр (<http://www.bloomberg.com/news/2014-04-24/japan-tobacco-forecasts-17-profit-drop-on-restructuring-costs.html>).

¹¹ ОУХБ-ын мэдээллийн алба, 2003 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр (http://www.ilo.org/global/about-the-ilo/newsroom/features/WCMS_071230/lang-en/index.html).

1.2 Ургац ба амьжиргааны эх үүсвэрийг орлуулах

Дэлхийн томоохон тамхи үйлдвэрлэгчид зэрэг цөөнгүй улс оронд тамхи тариалахаас бусад амьжиргааны эх үүсвэр бий болгоход анхаарч байна. Дэлхийн өөр өөр бүс нутагт хийсэн судалгаануудаар тамхины тариалалтыг орлох эдийн засгийн тогтвортой хэд хэдэн эх үүсвэрийг тодорхойлжээ.¹² Тамхины тариалалтыг орлох амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг тодорхойлохын тулд орлого, ургацын ашигтай байдлаас гадна тариаланчдын амьдрал ахуйн бүх асуудлыг харгалзан үзэх шаардлагатай. Асуудлыг цогцоор нь шийдвэрлэснээр судалгаа шинжилгээний үр дүн болон бодлогыг уялдуулах боломжтой болно.

1.3 Тамхи тариаланчид болон бусад ажилчдын ажил мэргэжлийн онцлогтой холбоотой эрсдэл

Тамхи тариаланчдын дунд тамхины ногоон эмгэг, пестицидын хордлого, амьсгалын замын болон арьсны өвчин, хорт хавдар зэрэг ажил мэргэжлийн онцлогтой холбоотой эрсдэлүүд байдаг. Тамхи тариаланчдад өвөрмөцөөр илэрдэг тамхины ногоон эмгэг¹³ нь никотин арьсаар шимэгдсэнтэй холбоотой үүсдэг бөгөөд нойтон навчтай харьцах үед эрсдэл нь нэмэгддэг боловч зохих хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэснээр сэргийлэх бүрэн боломжтой юм.¹⁴ Бидис хийх явцад тамхины тоосонцроор амьсгалснаас нэн Ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд амьсгалын замын өвчин эмгэг үүсдэг. Мөн энэ нь нэг байрлалд удаан хугацаагаар сууж хийдэг ажил учраас яс, булчингийн эмгэгт хүргэдэг байна.

1.4 Ажил эрхлэлтэд үзүүлэх үр нөлөө ба нийгмийн доройтол

Зарим улсад тамхи тариалахтай холбоотой ядуурал, нийгмийн доройтол нь ерийн боолчлол, хүүхдийн хөдөлмөрөөр илэрдэг.¹⁵ Тамхи тариалахтай холбоотой нийгмийн доройтлын талаарх илтгэлийг 2008 онд Мехико хотод хуралдсан Тамхи тариалахаас бусад амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг судлах ажлын хэсгийн хоёрдугаар уулзалтын үеэр танилцуулсан байна.¹⁶ Тамхи тариалахтай холбоотой нийгмийн доройтлыг ядуурал, шударга бус гэрээ, өрийн боолчлол, хүүхдийн хөдөлмөр зэрэгтэй уялдуулж хөгжлийн хандлагын үүднээс авч үзэх шаардлагатай. Өрийн боолчлол, хүүхдийн хөдөлмөр нь олон улсын эрх зүйд тогтоосон хүний эрхийг бүдүүлгээр зөрчиж байгаа асуудал тул ОУХБ, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр зэрэг холбогдох олон улсын байгууллагатай хамтран шийдвэрлэх нь зүйтэй.

¹² Ургац орлуулах боломжуудын товчоон. ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлтэй холбоотой ажлын хэсгийн гуравдугаар хуралдаанд танилцуулсан илтгэл, Женев, Швейцар, 2012 оны 2 дугаар сарын 14-16-ны өдрүүд.

¹³ Pereira Vasconcelos de Oliveira P, et al. First reported outbreak of green tobacco sickness in Brazil. *Cadernos de Saúde Pública*. 2010;26:2263-69.

¹⁴ Бразилийн тамхи тариаланчдын нийгэмлэгээс зөвлөмж болгосон хувийн хамгаалах хэрэгсэл нь ажилчдыг тамхины ногоон эмгэгээс сэргийлэхэд үр дүнгүй болохыг Пелотасын Холбооны их сургуулийн хийсэн судалгаагаар тогтоосон байна.

¹⁵ Хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой ОУХБ-ын конвенциуд

¹⁶ Отанез М. Тамхи тариалахтай холбоотой нийгмийн доройтол. Тамхи тариалахаас бусад амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг судлах ажлын хэсгийн хоёрдугаар уулзалтад зориулж хийсэн судалгаа, Мехико хот, 2008 оны 6 дугаар сарын 17-19-ний өдрүүд

1.5 Орчинд үзүүлэх нөлөө¹⁷

Хөгжиж буй цөөнгүй улс оронд тамхины тариалалт нь биологийн төрөл зүйлийн хорогдол, ургамлын аймгийн өөрчлөлтөд хүргэж байгаа нь тамхины навчийг хатаах түлш гаргаж авах, тариалангийн талбай чөлөөлөх (удаан ашигласан талбайн хөрсөн дэх шим тэжээл хорогдсоны улмаас шинээр талбай чөлөөлөх) зорилгоор ой мод ихээр сүйтгэж байгаатай холбоотой юм.¹⁸

Тамхи тариалахад дэлхийн ХАА-н нийт газар нутгийн 1 хүрэхгүй хувийг ашигладаг боловч ой мод сүйтгэхэд үзүүлж буй нөлөө нь үүнээс их байна.¹⁹ Зарим улсад хийсэн судалгаагаар тамхи тариалах нь ой сүйдэхэд нөлөөлдөг бусад бүх хүчин зүйлийн нийлбэрээс 10 дахин илүү хор хөнөөл учруулдаг гэсэн үр дүн гарчээ. Ой сүйдсэнтэй холбоотой нийгмийн-экологийн алдагдлын сөрөг үр дагаврыг тариаланчид дангаараа үүрдэг байна. Тамхийг өөр үр тариатай ээлжлэн тариалдаггүй тул хөрсөн дэх шим тэжээл шавхагдахад хүргэдэг.²⁰ Тамхи тариалахад нэгж талбайд шаардагдах пестицид, бордооны хэрэгцээ зарим нөхцөлд асар өндөр байдаг.²¹ Тамхи нь бордоо хамгийн ихээр шаарддаг 10 үр тарианы тоонд багтдаг.²²

1.6 Тамхины тариалалтыг орлох амьжиргааны тогтвортой эх үүсвэр бүрдүүлэхийн эсрэг тамхи үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа

ДЭМБ-ын ТХСК-ийн дагуу тамхины тариалалтыг орлох амьжиргааны эх үүсвэр бий болгох, тамхины эрэлтийг бууруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх нь тамхи тариалахтай холбоотой эдийн засгийн үр өгөөжийг цочир үгүй хийнэ гэж тамхи үйлдвэрлэгчид ухуулдаг. Ингэхдээ тэд тамхины тариалалтаас орон нутгийн болон үндэсний эдийн засагт оруулж буй хувь нэмэр, энэ салбарт ажиллагсдын тоо, худалдааны эргэлтэд тамхин бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ зэрэг тоо баримтуудаас иш татдаг байна.²³

Гэвч бодит амьдрал дээр тамхины хэрэглээ жилд нэг хүрэхгүй хувиар буурдаг тул тариаланчид засгийн газрын дэмжлэгтэйгээр аажмаар амьжиргааны өөр эх үүсвэр бүрдүүлэх бүрэн боломжтой юм. Харин ч тамхины тариалалтыг механикжуулах, олон улсын худалдааны өрсөлдөөн нэмэгдэх нь энэ салбарт ажлын байр хорогдуулахад илүүтэй нөлөөлж байна.²⁴ Тиймээс тамхи үйлдвэрлэгчдийн дээрх ухуулга үнэнд үл нийцнэ. Түүгээр ч үл барам Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос тус конвенцийн 5.3 дугаар зүйл болон түнийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу хамгаалах үүрэг хүлээдэг.

¹⁷ Энэхүү хэсэг нь FCTC/COP/3/11 баримт бичгийн холбогдох хэсэг (4 дүгээр хуудас, 17 дугаар догол мөр)-т тулгуурласан болно.

¹⁸ Yanda PZ. Impact of small scale tobacco growing on the spatial and temporal distribution of Miombo woodlands in Western Tanzania. *Journal of Ecology and the Natural Environment*. 2010;2:10-16.

¹⁹ Geist H. Global assessment of deforestation related to tobacco farming. *Tobacco Control*. 1999;8:18-28.

²⁰ Goodland JA, Watson C, Ledec G. *Environmental management in tropical agriculture*. Boulder (CO): Westview Press; 1984.

²¹ *Fertilizer use by crop*. Rome: Rome, Food and Agriculture Organization of the United Nations; 1999.

²² *Fertilizer use by crop*. Rome, Food and Agriculture Organization of the United Nations; 2006.

²³ Assunta M. Tobacco industry's ITGA fights FCTC implementation in the Uruguay negotiations. *Tobacco Control*, 26 May 2012. doi:10.1136/tobaccocontrol-2011-050222.

²⁴ *Tobacco industry interference with tobacco control*. Geneva: World Health Organization; 2008.

2. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ БА ХАМААРАЛ

2.1. Энэхүү удирдамжийн зорилго нь Оролцогч талуудыг ДЭМБ-ын ТХСК-ийн 17 ба 18 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай цогц бодлого, үр дүнтэй арга хэмжээг чиглүүлэхэд оршино.

2.2. Зөвлөмжүүд нь ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлийн хүрээнд тамхи тариаланчид болон бусад ажилчдыг тамхинаас өөр амьжиргааны тогтвортой эх үүсвэрээр хангах шинэлэг механизм бүрдүүлэх бодлого хэрэгжүүлэх Оролцогч талуудын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх зорилготой.

2.3. Оролцогч талуудад хүнсний баталгаат байдал, зохистой зах зээл, үүн дотроо тамхины тариалалтыг орлуулах байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихтэй уялдсан хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Төрийн байгууллагууд, нэн ялангуяа хөдөө орон нутагт нөлөө бүхий байгууллагууд тамхи тариаланчдад сургалт зохион байгуулах зэрэг бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх замаар тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны олон эх үүсвэр бий болгохыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын болон тариаланчдын байгууллагууд мөн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй оролцоно ("Үндсэн зарчим"-ын Зарчим 2-ыг харна уу).

2.4. Тамхи тариалахаас өөр амьжиргааны эх үүсвэр бий болгох бодлого, хөтөлбөрийг тодорхой хугацааны дотор үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж болно. Үүний зэрэгцээ тариаланчдад ХАА-н бус үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн баримжаа олгох хөтөлбөр хэрэгжүүлж, Энэ талаарх мэдээллийг сонирхогч талуудад хүргэнэ. Тамхин бүтээгдэхүүний эрэлт буурахад хэдэн арван жил шаардлагатай бөгөөд үүнд нийцүүлж нийлүүлэлтийг тохируулах зардал ч гэсэн мөн хугацаанд бага багаар гарна гэсэн үг. Шилжилтийн зардал ч гэсэн удаан хугацааны туршид бага багаар гарна. Улс орнууд сургалтын хөтөлбөр, мэдээллийн кампанит ажлын агуулгыг тоо мэдээ, шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлан боловсруулж, тариаланчдад тамхийг орлуулах амьжиргааны өөр эх үүсвэртэй холбоотой ташаа мэдээлэл хүрэхээс сэргийлнэ. Тамхи тариалдаг улс орнууд өөрийн нөхцөл байдал, тариаланчдын амьжиргааны эх үүсвэрийг орлуулах стратегийг хэрэгжүүлэх чадавхиас хамаарч хэрэгжих боломжтой зорилго, зорилтот түвшинг бодитоор тогтооно.

2.5. Оролцогч талууд энд зөвлөмж болгож буй арга хэмжээг аль болох өргөн хүрээнд хэрэгжүүлэхийн зэрэгцээ ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд зөвлөмж болгосноос бусад арга хэмжээг өөрийн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлж, ингэхдээ тамхи тариаланчид болон бусад ажилчдын амьжиргааг хохироохгүй байхад анхаарна. ДЭМБ-ын ТХСК нь тамхи тариаланчид, бусад ажилчид болон борлуулагчдыг шийтгэх зорилго агуулаагүй, харин тамхины хэрэглээ буурахын хирээр тэдэнд тамхинаас өөр амьжиргааны эх үүсвэр бий болгохыг хөхиүлэн дэмжих зорилготой юм.

3. ҮНДСЭН ЗАРЧИМ

Зарчим 1: Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үзэл баримтлалд тулгуурлан тамхийг орлуулах эдийн засгийн тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх.

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үзэл баримтлал нь тариаланчдад эдийн засгийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа төрөлжүүлэх өргөн сонголт олгоход чиглэдэг. Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгоно гэдэг нь тамхи тариалах улирлын хооронд өөр үр тариа тариалах, сөөлжлөн тариалах, нэг үр тариаг нөгөөгөөр орлуулахаас өргөн хүрээтэй ойлголт юм. Энэ нь нэн ялангуяа ядуу хөдөө орон нутагт оршин суудаг тамхи тариалдаг гэр бүлүүдийн өртөмтгий байдлыг бууруулах сонголтыг бий болгох үр дүнтэй цогц стратеги юм.

Энэхүү сонголт нь тамхи тариаланчдад эрүүл мэнд, нийгэм- эдийн засгийн сайн сайхан байдлаа дээшлүүлэх боломж олгоход чиглэнэ. Иймд амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох асуудлыг тариан талбайгаар хязгаарлалгүй илүү өргөн хүрээтэй хөгжлийн стратегитай нэгтгэж, үр дүнтэй, тогтвортой хэрэгжилтийг хангана.

ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх бодлого нь эдийн засгийн болон үйлдвэрлэлийн асуудлыг төдийгүй ажилчдын сайн сайхан байдал, амьдралын чанар, байгаль орчныг хамгаалах асуудлыг хамарсан цогц бодлого байна. Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үзэл баримтлал нь өрх гэрийн амьжиргаа дараах таван төрлийн баялгаас хамаардаг гэж үздэг. Үүнд: байгалийн (газар, мал), хүний (хөдөлмөр, боловсрол), биет (дэд бүтэц), санхүүгийн (хуримтлал, орлого) ба нийгмийн баялаг (нийгмийн харилцааны сүлжээ, нийгмийн бүтэц).

Зарчим 2: ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх бодлого боловсруулахад тус конвенцийн 5.3 дугаар зүйл, түүнийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу тамхи тариаланчид болон бусад ажилчдыг оролцуулах.

Тамхи тариаланчид болон бусад ажилчдыг 17,18 дугаар зүйлтэй холбоотой бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн оролцуулж, тэдний оролцоог тамхи үйлдвэрлэгчдийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос хамгаална.

Байгаа нөөцийг үр ашигтай ашиглахын тулд олон салбарын хамтын ажиллагааг хангах нь зүйтэй. Конвенцийн 17, 18дугаар зүйлтэй холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд тариаланчдыг оролцуулахын тулд тэдэнд өөрсдийн санал бодлоо илэрхийлэх зохистой суваг бий болгох шаардлагатай.

Зарчим 3: Тамхийг орлох амьжиргааны тогтвортой эх үүсвэр бий болгох бодлого, хөтөлбөр нь шилдэг туршлагад тулгуурлах, тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй уялдсан байх

Тамхины үйлдвэрлэлийг эдийн засгийн өөр үйл ажиллагаагаар амжилттай орлохын тулд тухайн үйл ажиллагаа нь ашигтай байх, нэн ялангуяа шилжилтийн хугацаанд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, судалгаа хийх, чадавхи бэхжүүлэх, зах зээлийн болон нийгмийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Зохимжтой бол санхүүгийн механизм бүрдүүлнэ.

Орлуулах үйл ажиллагаа нь тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжих, ядуурлыг бууруулах, байгаль орчинд хор хөнөөл багатайгаар байгалийн нөөцийг тогтвортой удирдах чадавхийг бэхжүүлэх, нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг багасгах зарчимд тулгуурласан байх нь зүйтэй.

Эдийн засгийн хувьд тогтвортой амьжиргааны бусад эх үүсвэрийг хөхиүлэн дэмжих бодлого нь цогц, олон салбарыг хамарсан, ДЭМБ-ын ТХСК-ийн зорилтод нийцсэн, тамхины тариалалтын эдийн засгийн богино хугацааны ашиг төдийгүй тамхины тариалалт, боловсруулалттай холбоотой далд зардлуудыг давхар тооцсон байвал зохино. Төрийн зүгээс тамхи тариалах бизнес шинээр эрхлэхийг дэмжсэн эсхүл тамхи тариаланчдыг амьжиргааны өөр эх үүсвэртэй болоход саад уруулах арга хэмжээ хэрэгжүүлэхээс татгалзана. Түүнчлэн тамхийг орлуулах үр тариа тариалахыг дэмжих, боловсрол олгох, мэдээлэл өгөх үйл ажиллагааг санхүүжүүлэх механизм бүрдүүлнэ. Түүнчлэн энэхүү бодлогыг тогтвортой хөгжлийг дэмжих төрийн бодлого, хөтөлбөртэй нэгтгэх талаар хүчин чармайлт гаргах нь зүйтэй.

Зарчим 4: Эдийн засгийн хувьд тогтвортой амьжиргааны бусад эх үүсвэрийг хөхиүлэн дэмжихдээ тамхи тариаланчид болон бусад ажилчдын амьжиргааны бүх (эрүүл мэндийн, эдийн засгийн, нийгмийн, орчны, хүнсний баталгаат байдлын асуудлыг харгалзах

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох арга хэмжээг газар тариаланчдын амьдралын чанарын баталгааг хангах нийгмийн бодлогоор дамжуулж газар тариалангийн хөгжлийн ерөнхий бодлоготой нэгтгэх хэрэгтэй. Эдгээр бодлого нь бүс нутгийн болон орон нутгийн нөөцийг бүрэн ашиглахыг зорино.

Тамхи тариалж байгаа хүн бүр тамхи тариалах нь түүний эрүүл мэнд болон байгаль орчинд ямар эрсдэл учруулж байгаа, үүнээс хэрхэн сэргийлэх талаар бүрэн мэдээлэл авах эрхтэй (4.2 дугаар хэсгээс харна уу). Ажилчдын эрүүл мэнд болон байгаль орчныг хамгаалах үндэсний хөтөлбөр, бодлогын хүрээнд тамхины үйлдвэрлэлтэй холбоотой эрсдэлийг бууруулах асуудалд мөн анхаарна.

Амьжиргааны бусад эх үүсвэр бүрдүүлэх үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахын тулд орон нутгийн, үндэсний, бус нутгийн болон олон улсын түвшинд хүний нөөцийн, материаллаг болон санхүүгийн хангалттай нөөц бүрдүүлэх шаардлагатай.

Зарчим 5: Эдийн засгийн хувьд тогтвортой амьжиргааны бусад эх үүсвэрийг хөхиүлэн дэмжих бодлогыг ДЭМБ-ын ТХСК-ийн 5.3 дугаар зүйл, түүнийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу тамхи үйлдвэрлэгчид болон навчны компаниудын худалдааны ба бусад уламжлалт ашиг сонирхлоос хамгаалах.

Тамхи үйлдвэрлэгчид болон нийгмийн эрүүл мэндийн хооронд эвлэршгүй, суурь ашиг сонирхлын зөрчил байдаг. Тамхи үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэн, сурталчилдаг бүтээгдэхүүн нь донтуулах нөлөөтэй бөгөөд өвчлөл, нас баралтад хүргэдэг, ядуурал зэрэг нийгмийн олон сөрөг үр дагаварт хүргэдэг болох нь судалгаа шинжилгээгээр нотлогдсон байна. Иймд Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх механизм бүрдүүлэх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагааг тамхи үйлдвэрлэгчдийн нөлөөллөөс хамгаалах ёстой. Тамхи тариалах, ханган нийлүүлэхтэй холбоотой болох нь батлагдсан эрүүл мэнд болон байгаль орчинд учирч буй хор хөнөөлийн хариуцлагыг тамхи үйлдвэрлэгчид хүлээж, тамхи тариалах, ханган нийлүүлэх салбарт ажиллаж буй хүмүүсийн хүний эрхийг баталгаажуулах үүрэгтэй.

Зарчим 6: Дээрх бодлого, зөвлөмжийг хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн ба/буюу санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлах.

Амьжиргааны бусад эх үүсвэр бүрдүүлэх үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахын тулд орон нутгийн, үндэсний, бус нутгийн болон олон улсын түвшинд хүний нөөцийн, материаллаг болон санхүүгийн хангалттай нөөц бүрдүүлэх шаардлагатай. Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахын тулд ДЭМБ-ын ТХСК-ийн 26 дугаар зүйлд заасанчлан санхүүгийн байгаа нөөцийг дайчлахын зэрэгцээ бусад боломжит эх үүсвэрийг эрэлхийлнэ. Шаардлагатай бол Оролцогч талууд амьжиргааны бусад эх үүсвэр бүрдүүлэх хөшүүрэг бий болгож, тамхины тариалалтыг дэмжсэн арга хэмжээ хэрэгжүүлэхээс татгалзана.

ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлээр хүлээсэн үүргээ биелүүлэх Оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх, бүх түвшинд тамхины үйлдвэрлэлийн нийгэм-эдийн засгийн болон орчны үр дагаврыг амжилттай саармагжуулахад олон улсын хамтын ажиллагаа, харилцан дэмжлэг, үр ашигтай технологи болон мэдээлэл, мэдлэг, мэргэжлийн чадавхийг харилцан солилцох нь амин чухал юм. Оролцогч талууд конвенцийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ, арга ажиллагаа, удирдамж боловсруулах чиглэлээр хоорондоо болон бүсийн, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, хоёр ба олон талт санхүүжилтийн механизмыг ашиглах үүргийг конвенцийн 4.3, 5.4, 5.5, 20, 21, 22, 26 дугаар зүйлийн дагуу хүлээдэг байна.

4. ТАМХИЙГ ОРЛУУЛАХ ҮР ТАРИА, АМЬЖИРГААНЫ ЭХ ҮҮСВЭРИЙГ ТОДОРХОЙЛЖ, ТАМХИ ТАРИАЛАНЧДЫГ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ТАМХИНЫ ҮЙЛДВЭРЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ХОР ХӨНӨӨЛӨӨС ХАМГААЛАХ ҮР ДҮНТЭЙ СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ

Тариаланчид тамхи тариалахыг илүүд үздэг зарим шалтгаанаас дурдвал:

- Навчны компаниуд тамхи тариаланчидтай нийлүүлэлтийн гэрээ байгуулдаг нь тариаланчдад нэг талаар "баталгаа" болдог ба зарим тохиолдолд навчны компаниуд тамхи тариаланчдад зээл, бусад урамшуулал олгож, тамхи үйлдвэрлэгчид зах зээлийн баталгаагаар хангадаг нь санаа амар байх боломжоор хангадаг;
- Цөөнгүй тохиолдолд тариаланчид тамхины үйлдвэрлэлээс бүрэн хараат болсон байдаг ба орон нутгийн түвшинд улс төрчид, менежер, тамхи үйлдвэрлэгчдийн хооронд бие биенээ дэмжих харилцаа нэгэнт тогтсон байдаг тул орон нутгийн түвшинд тамхийг орлуулах амьжиргааны эх үүсвэр бүрдүүлэх санаачилга улс төрийн дэмжлэг авч чадахгүй байх нь түгээмэл юм;
- Тамхи тариаланчид болон бусад ажилчид тамхи бусад үр тарианаас илүү ашигтай гэж итгэдэг;
- Итгэл үнэмшил ба зан заншил зарим бүс нутагт удам дамжин тамхи тариалдаг ба тамхи тариалахтай холбоотой зан заншлыг үеэс үед дамжуулдаг;
- Тамхинаас өөр үр тариа тариалахад олох орлого, зах зээлийн боломжийн талаарх эргэлзээ их, өөр үр тариа тариалахад хөрөнгө

оруулах нөөц хязгаарлагдмал; Тариаланчид нэгэнт тогтсон арга ажиллагаагаа өөрчлөхөөс цаарагласан хуучинсаг үзэлтэй;

- Тамхины ургамал ганд тэсвэртэй тул усалгаа муутай, хөрс, цаг уурын таагүй нөхцөлтэй бүс нутагт тамхи тариалах нь бусад үр тариатай харьцуулахад илүү ашигтай гэж үздэг.

Зөвлөмж

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратеги нь тамхи үйлдвэрлэлийг орлох газар тариалангийн болон газар тариалангийн бус боломжуудыг хамарсан байвал зохино. Гэхдээ эдийн засгийн нэг үйл ажиллагааг нөгөөгөөр орлуулснаар тамхи тариаланчдын болон бусад ажилчдын ядуурал, эмзэг байдлыг бүрэн шийдвэрлэж чаддаггүй.

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратеги нь газар тариалангийн салбарын тогтвортой хөгжлийн алсын хараатай уялдах ёстой. Энэхүү стратегид хүнсний баталгаат байдлыг хангахад чиглэсэн үйлдвэрлэл, орон нутгийн зах зээлтэй холбосон ханган нийлүүлэлтийн сүлжээ, газар тариалангийн болон газар тариалангийн бус үйл ажиллагааг хослуулах асуудлыг тусгана.

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратеги нь үйл ажиллагааны хүрээ болон бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, зах зээлийг өргөжүүлэх замаар улирлын чанартай газар тариалангийн орлогыг тогтмол орлогоор орлуулахыг зорино. Түүнчлэн ХАА-н инноваци, техникийн шинэчлэлийг дэмжиж, мал, ургамал, газрын ашиглалтын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх замаар нөөцийн хэмнэлт бий болгоно. Улмаар хөдөө орон нутагт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа өргөжиж, нөөц нэмэгдэнэ.

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратеги нь орлого нэмэгдүүлэх, гүйлгээний зардлыг бууруулах хамтын ажиллагаа, орон нутгийн харилцаа холбооны шинэ хэлбэрийг хөхиүлэн дэмжих ёстой. Эдгээр өөрчлөлт Нв тариаланчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, хэрэглэгчидтэй харилцах харилцааг өргөжүүлж, нөхцөл байдалтай зохицох уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратеги нь зах зээлийн эрэлт, хөдлөл зүйд тулгуурлах нь зүйтэй.

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратеги хэрэгжүүлж буй бүс нутагт газар тариалан, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудын интеграцийг дэмжсэн Орчин бүрдүүлбэл зохино. Түүнчлэн тогтвортой байдлыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн хэлбэлзэл, орлогын эх үүсвэртэй холбоотой эмзэг байдлыг бууруулахад чиглэнэ. Цар хүрээний хэмнэлт нь гүйлгээний зардлыг бууруулж, үр өгөөжийн халих шинжийг нэмэгдүүлнэ.

Тамхи тариалахаас амьжиргааны өөр эх үүсвэрт шилжих үед тариаланчдыг өргөн хүрээний нөөц, боломжоор хангах салбар хоорондын санаачилгуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр санаачилга нь зах зээлийн чиг баримжаатай байх ба халамжийн үзэл санаанд тулгуурлаж болохгүй. Шилжилт нь тариаланчдын бие даасан байдлыг бэхжүүлэх, газар тариалангийн болон газар тариалангийн бус орлогын олон эх үүсвэр бий болгох, хөрсний шим тэжээлийг нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хадгалах, үр өгөөжийн халих шинжийг нэмэгдүүлэх, нийгмийн эрүүл мэндийн зорилтод анхаарах хөгжлийн стратегийг хөхиүлэн дэмжих ёстой.

4.1 Судалгаа шинжилгээг хөхиүлэн дэмжих

Судалгаа шинжилгээний ажлыг цогц байдлаар хийж, ашиг, эрүүл мэндийн, байгаль орчны болон нийгэм-эдийн засгийн өртөг зэрэг тамхи тариалахтай холбоотой бүх асуудлыг хамруулна. Мөн өөр өөр төрлийн үр тариа тариалах нь тариаланчдын амьдралын чанарт хэрхэн нөлөөлж байгааг тооцоолж, дүн шинжилгээ хийх нь зүйтэй. Тамхи болон бусад үр тарианы эрэлт, зах зээлийн хэмжээг харьцуулна. Судалгаа шинжилгээний ажлын хүрээнд орчинд үзүүлэх нөлөө, хөгжил, ядуурлын асуудлуудыг анхаарвал зохино. Судалгаа шинжилгээний ажилд шийдвэр гаргагчдыг идэвхтэй оролцуулах хэрэгтэй. Мөн олон улсын байгууллагууд үндэсний судалгаа шинжилгээний ажилд мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэхийг хөхиүлэн дэмжинэ.

Судалгаа шинжилгээний хүрээнд дараах асуудлыг хамруулах нь зүйтэй. Үүнд:

- a) **Тамхины салбарын төлөв байдал, үндсэн шинж чанар болон тамхины тариалалтын эдийн засгийн судалгаа.** Үүнд тамхи тариаланчдын болон бусад ажилчдын тоо, тамхины тариалангийн талбай, талбайн хэмжээний ангилал тус бүрт хамаарч буй тариаланчдын болон бусад ажилчдын тоо, тамхины ургацын хэмжээ (нэг тариалангийн талбайд ногдох болон талбайн ангилал тус бүрээр), тамхи тариаланчдын болон бусад ажилчдын нас, хүйс, боловсролын байдал, тариалж буй тамхины төрөл, тамхины фермд ажиллагсдын тоо, тамхи тариаланчдын болон бусад ажилчдын ажлын өдрийн тоо зэрэг тамхи тариалахтай холбоотой бүхий л мэдээллийг хамруулбал зохино.
- b) **Хүнсний үр тарианы эрэлтийн урьдчилсан тооцоо судалгаа.** Улс орон болгон хүнсний цаашдын хэрэгцээний судалгаа хийж, хүнсний ногоо, жимс зэрэг бусад үр тарианы тариалалтын үр нөлөө, үнийн урьдчилсан тооцооллыг хийнэ. Тамхи тариалдаг бүс нутагт газрын ашиглалттай холбоотой мэдээ цуглуулж, хүнсний үр тарианд ашиглаж байсан газрыг тамхины тариалангийн талбай болгон өөрчилсөн эсэх, тамхины талбайг хүнсний үр тарианы талбай болгосон эсэхийг тодруулна.
- c) **Орчны болон эрүүл мэндийн нөлөөллийн судалгаа.** Тамхи болон бусад үр тариа тариалахтай холбоотой ой мод сүйдэх, ус бохирдох, хөрс эвдрэх, үр шимгүй болох, уур амьсгал өөрчлөгдөх, зэрлэг ан амьтны тоо толгой хорогдох болон экологийн бусад нөлөөг харьцуулан судална. Ингэхдээ тамхи болон бусад үр тариа тариалахад ашигладаг бордоо, химийн бусад бодисын нөлөөг харгалзан судална. Тамхины тариалалттай холбоотой эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг үндэсний эрүүл мэндийн тандалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болгох нь зүйтэй.
- d) **Тамхины түүхий эд үйлдвэрлэлийн эдийн засгийн судалгаа.** Тамхи тариаланчдаас тамхины түүхий эд худалдаж авах үнэ зэрэг тамхины эдийн засгийн судалгааг бүс нутаг болон тамхины төрөл тус бүрээр хийнэ. Мөн газрыг тамхи тариалахаас бусад зорилгоор ашиглахтай холбоотой эдийн засгийн үр нөлөөг судална.
- e) **Тамхийг орлуулах амьжиргааны эх үүсвэрийн талаарх судалгаа.** Тамхийг орлуулах амьжиргааны эх үүсвэртэй холбоотой тариалалтын нөхцөл, ургацын хэмжээ, нэмүү өртгийн сүлжээ, стандартын шаардлага, зах зээл, үнэ, олон улсын худалдаа, эдийн засгийн бусад хүчин зүйлийн

талаар мэдээлэл цуглуулна. Тамхийг орлуулах амьжиргааны эх үүсвэр тус бүрийн хувьд хэрэгжүүлэх боломжийн судалгаа хийнэ. Үүнд олон улсын шинжээчдээс мэргэжил арга зүйн дэмжлэг авч болно.

- f) **Тэргүүлэх чиглэлийн жагсаалт.** Дээрх (a)-(e) хэсгүүдэд заасан мэдээлэлд тулгуурлан тамхийг орлуулах амьжиргааны эх үүсвэрүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлж, туршиж үзнэ.
- g) **Туршилт судалгаа.** Тамхийг орлох үр тарианы эдийн засгийн тогтвортой байдлыг тодорхойлох туршилт судалгаа хийж болно. Туршилтыг судалгааны хүрээлэн буюу их сургуулийн туршилтын талбайд бус, харин тамхи тариаланчидтай хамтарч тариан талбайд нь хийнэ. Туршилт судалгааг тамхи тариалдаг томоохон бүс нутгуудад нэгэн зэрэг хийж гүйцэтгэсний үндсэн дээр дүгнэлт хийх ба судалгааг нэгдсэн стандарт аргачлалын дагуу хийнэ.
- h) **Бизнес төлөвлөгөө боловсруулах.** Туршилт судалгааг амжилттай хийж гүйцэтгэж, тариаланчдад тамхийг орлох үр тарианы талаар итгэл үнэмшил төрүүлсний үндсэн дээр бизнес төлөвлөгөө боловсруулж, үүнд түүхий эдийг хэрхэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгох (нэмүү өртгийн сүлжээ) асуудлыг мөн тусгана.

Төрийн бус байгууллага болон бусад холбогдох байгууллагын оролцоо чухал. Шаардлагатай бол мэдээллийн төвүүдийг (4.8 дугаар хэсгээс харна уу) байгуулж, төлөвлөлт, сургалт, үйлчилгээ, туршилтын үнэлгээнд татан оролцуулна.

Дээрх (a)-(h) хэсгүүдэд заасан мэдээллийг стандарт асуумж зэрэг нэгдсэн стандарт арга, аргачлалаар цуглуулж, олон улсын мэдээний санд байршуулах шаардлагатай (6.5 дугаар хэсгээс харна уу). Судалгаа шинжилгээний үр дүнг практикт нэвтрүүлэх талаар хүчин чармайлт гаргах шаардлагатай. Тухайлбал, судлагдаагүй асуудлаар нэмж судалгаа хийх, зах зээлийн судалгаа хийх зэргээр тамхийг орлуулах үр тариаг зах зээл дээр борлуулах боломжийг нэмэгдүүлэх. Энэ ажлыг шаардлагатай бол мэдээллийн төвүүдээр гүйцэтгүүлж болно.

Өмнө нь хийсэн судалгаа, хуримтлуулсан туршлага, хэрэгжүүлсэн төсөл, туршилт судалгаа зэргийг мөн харгалзан үзэх нь зүйтэй. Санхүүжилтийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн олон эх үүсвэрээс, үүн дотроо тамхинаас олсон орлогоос гаргаж болно.

Хүлээгдэж буй үр дүн

1. Дэлхийн хэмжээнд тамхины үйлдвэрлэл, эдийн засгийн сүлжээний өнөөгийн нөхцөл байдал, хандлагын тухай стандарт асуумжийн дагуу цуглуулсан мэдээлэл, үүнд ажиллагсдын ТОО, үйл ажиллагааны төрөл, тамхи тариаланчдын амьжиргаа;
2. Тамхины тариалалтын орчны ба эрүүл мэндийн нөлөөллийн сүүлийн үеийн судалгаа, улс орны тамхи тариалдаг бус нутаг тус бүрээр;
3. Өөр өөр үр тарианы эрэлтийн урьдчилсан тооцоо, улс орон тус бүрээр;
4. Стандарт аргачлалын дагуу бүс нутаг, тамхины ургамлын төрөл тус бүрээр бүрдүүлсэн тамхины түүхий эдийн үйлдвэрлэлийн эдийн засгийн мэдээний сан;
5. Тамхийг орлуулах эдийн засгийн тогтвортой үйл ажиллагаа, тэдгээрийн эдийн засгийн сүлжээтэй холбоотой тоо мэдээ;

6. Тамхийг орлуулах амьжиргааны эх үүсвэрийн тэргүүлэх чиглэлийн жагсаалт, эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургуулиудын стандарт аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн тэдгээртэй холбоотой судалгааны үр дүн, улс орон тус бүрээр;
7. Тамхийг орлуулах амьжиргааны эх үүсвэр тус бүрийн нэмүү өртгийн сүлжээтэй холбоотой бизнес төлөвлөгөө, улс орон тус бүрээр.

4.2 Тамхи тариаланчид болон бусад ажилчдад зориулсан боловсрол олгох ба сургалтын хөтөлбөр боловсруулах

Боловсрол олгох хөтөлбөр боловсруулахдаа зорилтот хүн амын нас, хүйс, яс үндэс, боловсролын түвшин зэргийг ойлгох нь чухал юм. Иймд боловсролын хөтөлбөр боловсруулахын өмнө судалгаа хийж, дараах хоёр асуудлыг харгалзана. Үүнд:

1. Сургагч багш бэлдэх нь тамхи тариаланчид болон бусад ажилчдад тамхийг орлуулах үр тариатай холбоотой үр чадвар эзэмшүүлэх сонгодог арга юм. "Цуваа сургалт"-ын зорилго нь өөр өөр түвшин (ж.нь, дүүргийн буюу орон нутгийн түвшин)-д ажиллаж буй мэргэжил нэгтнүүд бие биедээ мэдлэг, үр чадвараа шилжүүлэхэд оршино. Сургагч багшид сайн багшлах үр чадварыг "хийж суралцах" арга барилаар эзэмшүүлэх нь зүйтэй. Сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад хүмүүсийн хоорондын харилцаа асар чухал. Тамхи тариаланчдад өөр үр тариа тариалах үр чадвар эзэмшүүлэхэд газар тариаланчдын нийгэмлэгүүдийг татан оролцуулах нь зүйтэй.
2. Тамхи тариалдаг бүс нутгийн газар тариалангийн сургууль болон эрх бүхий байгууллагуудын сургалтын хөтөлбөрт тамхинаас өөр үр тариа тариалах Газар тариалангийн зохистой дадал (GAP)-ын асуудлыг тусгах шаардлагатай.²⁵ Оролцогч талууд тамхи болон бусад үр тариатай холбоотой хөрсний менежмент, шавжгүйтгэл, усны менежмент, Химийн бодис, бордоо, тоног төхөөрөмжийн хэрэглээ зэрэг газар тариалангийн бүхий л үйл ажиллагаанд GAP-ын үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ.

Боловсролын хөтөлбөр нь тогтвортой хөгжлийн (нийгмийн, эдийн засгийн, байгаль орчны) зарчимд нийцсэн, байгалийн нөөцийг тогтвортой удирдах, орчны сөрөг нөлөөллийг багасгах, нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг бууруулах шинэ үйл ажиллагааг удирдах үр чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн байна.

Боловсролын хөтөлбөрийн хүрээнд тамхины тариалалттай холбоотой эрүүл мэндийн болон орчны сөрөг нөлөөллийн талаарх мэдээллийг тамхи тариаланчид болон хэрэглэгчдэд түгээх асуудлыг тусгана. Түүнчлэн тамхийг орлох үр тариа, ажил мэргэжил, амьжиргааны эх үүсвэр, мэргэжил аргазүйн дэмжлэг, орлого, эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн талаарх мэдээллийг тариаланчдад өгнө.

4.3 Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгоход учирч болзошгүй саад бэрхшээлийг арилгах

Тамхийг орлуулах үр тарианы эдийн засгийн боломж нь тамхи тариаланчдын шийдвэрт нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Гэхдээ тамхи төсвийн,

²⁵ Good agricultural practices - a working concept. Rome: Food and Agriculture Organization of the United Nations; 2004 (FAO GAP Working Paper, No.5; <http://www.fao.org/prods/gap/Docs/PDF/5-GAPworkingConceptPaperEXTERNAL.pdf>)

нэн ялангуяа орон нутгийн төсвийн орлогын чухал эх сурвалж болдог тул өөр үр тариа тариалах нь тариаланчдад тамхинаас илүү ашигтай байсан ч түүнийг дэмжих улс төрийн чин эрмэлзэл үгүйлэгдэж болно. Зарим тохиолдолд тамхи үйлдвэрлэгчид ДЭМБ-ын ТХСК-ийн 17 дугаар зүйлийн хэрэгжилтийг саатуулах зорилгоор тамхи тариалах улирлын хооронд өөр үр тариа тариалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ухуулга нөлөөллийн ажлыг орон нутгийн удирдлагуудад зохион байгуулдаг.

Оролцогч талууд тамхитай холбоотой өр, өрийн боолчлол, хүүхдийн хөдөлмөр зэрэг тамхины тариалалтаас татгалзахад учирч буй аливаа саад бэрхшээлийг арилгах шаардлагатай. Үүний тулд Оролцогч талууд тариаланчдад туслах байгууллага байгуулах, ОУХБ-ын конвенц зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг бэхжүүлэх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Дараах саад бэрхшээл түгээмэл тохиолддог. Үүнд:

1. Орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулах санхүүгийн нөөц хязгаарлагдмал байх. Урт хугацааны санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх, амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох хөтөлбөрийг хөдөө орон нутгийг хөгжүүлэх үндэсний бодлогод тусгах замаар энэхүү саад бэрхшээлийг даван туулах боломжтой (6.3 дугаар хэсгээс харна уу).
2. Тамхи үйлдвэрлэгчид хууль тогтоогч, бодлого боловсруулагч нарыг лоббидох.
3. Тамхи тариаланчид болон бусад ажилчдын нийгэм- эдийн засгийн байдал. Ихэнх тохиолдолд нэн ялангуяа хөгжиж буй улс орнуудад тамхи тариаланчид болон бусад ажилчид газар өмчилж чаддаггүй, зөвхөн түрээсэлж газар тариалан эрхэлдэг. Тиймээс тэд ашиг ихтэй үр тариа тариалахыг эрмэлздэг. Ихэнх тохиолдолд тамхинаас өөр үр тариа тариалахад шаардлагатай хөрөнгө оруулалт хийх санхүүгийн нөөц бололцоо тариаланчдад байдаггүй. Түүнчлэн навчны компаниуд тамхи тариалахад зориулж дэмжлэг үзүүлдэг байна. тариаланчдад зээл олгож, Энэхүү зээл нь тамхи тариалах хүчтэй хөшүүрэг болдог. Ер нь, тариаланчид тамхи үйлдвэрлэгчдийн бий болгосон өрийн сүлжээнд баригдаж, төрийн бодлого/хөтөлбөрийн дэмжлэггүйгээр өрийн дарамтаас гарч чаддаггүй.

4.4 Яам/газруудын бодлогын уялдааг хангах

Тамхины тариалалттай холбоотой бүх салбарын үйл ажиллагааг хооронд нь зохицуулах нь амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгоход ач холбогдолтой. Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн дагуу өөр өөр яам/газруудын бодлогын уялдааг хангахад анхаарна.

Түүнчлэн тогтвортой хөгжлийн санхүүжилтийн механизм, санаачилгуудын хоорондын уялдааг хангах нь тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгоход зайлшгүй шаардлагатай. Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох, хөдөөгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд санхүүжилтийг чиглүүлэх сувгуудыг бий болгоно. Тамхи тариалахыг дэмжсэн хөшүүрэг, санхүүжилтийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн, тариаланчдад учирч болзошгүй сөрөг үр дагаврыг харгалзан зогсооно.

Санал болгож буй арга хэмжээ

1. Улс орнууд тамхи тариалахад ашигладаг талбайг нэмэгдүүлэх хөшүүрэг бий болгохоос татгалзах шаардлагатай.

2. Тамхи тариалдаг улс орнууд тамхины үйлдвэрлэлд зориулдаг төсвийн хөрөнгө/татаасыг амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгоход хуваарилах нь зүйтэй.

4.5 Тамхины тариалалт, тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих тамхи үйлдвэрлэгчдийн стратегийг илрүүлж, зохицуулах

Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчдийн тариаланчдад ашиггүй үнэ, нөхцөл тогтоох, хөдөлмөрлөх эрхийг зөрчих, "компанийн нийгмийн хариуцлага" нэрийн дор явуулах аливаа хууль бус үйлдлээс тамхи тариаланчид болон бусад ажилчдыг хамгаалах бодлого боловсруулна.

Иргэний нийгмийн байгууллагууд эдгээр хууль бус үйлдэлд хяналт тавих, илчлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадна.

Оролцогч талууд хөдөлмөрийн харилцаа, ажилчдын эрүүл мэндтэй холбоотой тамхи үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг хянах, шалгах зохицуулалтын механизм бүрдүүлж, сайжруулах ёстой.

Оролцогч талууд орчны доройтолд хүргэх газар тариалалтын үйл ажиллагааг илрүүлж, зохицуулна. Мөн тариаланчдын бие даасан байдал, тэдэнд чиглэсэн "компанийн нийгмийн хариуцлага"-ын үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих бодлого боловсруулна. Иймд тамхийг орлох амьжиргааны бусад эх үүсвэрийн богино, дунд, урт хугацааны үр өгөөжийг сурталчлах үйл ажиллагааг орон нутгийн түншүүд болон тариаланчдад зориулж явуулах нь чухал ач холбогдолтой.

4.6 Тамхийг орлох амьжиргааны бусад эх үүсвэр бүрдүүлэх асуудлыг хөдөөгийн хөгжлийг дэмжих засгийн газрын хөтөлбөрүүдийн цөм болгох

Тамхийг орлох амьжиргааны бусад эх үүсвэр бүрдүүлэх асуудлыг бодлогын цөм болгон хөгжүүлэхийн тулд хөдөө орон нутгийг хөгжүүлэх, хүнсний баталгаат байдлыг хангах засгийн газрын урт хугацааны төлөвлөгөөнд тусгах шаардлагатай. Тариаланчдад чиглэсэн аливаа үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргаа чухал үүрэгтэй тул тэдгээрийн үр дүнтэй оролцоог хөхиүлэн дэмжих механизм бүрдүүлэх нь чухал юм. Засгийн газрын зүгээс ДЭМБ-ын ТХСК-ийн 5 дугаар зүйлд нийцүүлэн энэ чиглэлээр урт хугацааны цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

4.7 Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгохыг дэмжих механизм бүрдүүлэх

Тамхийг орлох амьжиргааны бусад эх үүсвэрт шилжих хугацаанд тариаланчдад дэмжлэг үзүүлж, нөөц, боломжоор хангахад салбар хоорондын хамтын ажиллагааны бодлоготой байх нь амин чухал юм. Энэ нь халамжийн шинжтэй байх ёсгүй, харин тариаланчдад үзүүлэх төрийн дэмжлэг хэлбэртэй байна.

Тамхи тариаланчид болон бусад ажилчдыг шийдвэр гаргалтад оролцуулж, өөрсдийн хэрэгцээ шаардлага, санал бодлоо илэрхийлэх боломжоор зохих ёсоор хангана ("Үндсэн зарчим"-ын Зарчим 2-оос харна уу).

Өөрийн орны нөхцөл байдалд тохируулан тамхи тариаланчид болон бусад ажилчдыг амьжиргааны өөр эх үүсвэрт шилжихийг дэмжих зарим арга хэмжээний жишээг дор толилуулав:

- **Хөдөөгийн зээл** - тамхинаас өөр амьжиргааны эх үүсвэрт шилжих зорилгоор хөрөнгө оруулалт хийхэд зориулсан хөнгөлөлттэй зээл. Тариаланчид өөрсдөө хоршоо байгуулах, хамтын буюу өрхийн бизнес эрхлэхэд зориулж зээл олгохыг илүүд үзнэ.
- **Хүнсний баталгаат байдлыг хангах хөтөлбөрийн хүрээн дэх хүнсний худалдан авалт** - сургууль, эмнэлэг, хорих анги зэрэг байгууллагын зах зээлийг хүнсээр хангах, хүнсний нөөц бүрдүүлэх худалдан авалтыг хуучин тамхи тариаланчдаас хийнэ.
- **Өрхийн газар тариалангийн бүтээгдэхүүний үнийн баталгааг хангах** - өрхийн газар тариалангийн даатгалаар дамжуулж орлогын баталгааг хангана.
- **Мэргэжил аргазүйн дэмжлэг** - мэдлэг, туршлага түгээх чадвартай төрийн болон төрийн бус байгууллага, тариаланчдыг нэгтгэн, мэргэжлийн өндөр түвшинд цогц дэмжлэг үзүүлнэ.
- **Газар тариалангийн шинэчлэл ба зээл** - ихэнх тамхи тариаланчид тариалангийн газрыг түрээсээр ашигладаг буюу бага хэмжээний газар өмчилдөг болохыг харгалзан шинэчлэлийг төлөвлөнө.
- **Нийгмийн болон эдийн засгийн байгууллага** - тамхийг орлох ямар үр тариа, үйл ажиллагаа тухайн бүс нутагт тариаланчдын орлогыг бууруулахгүй байхыг тодорхойлно.
- **Дэд бүтэц ба үйлчилгээ** - тамхийг орлох үр тариа тариалахаар шийдсэн тариаланчдад шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.
- **Үр тариа ба орлогын даатгал** - даатгалын үндэсний газар компани байгуулж, газар тариалангийн тариалангийн найдвартай, эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжинэ.
- **Хоршоо** - тамхийг орлох үр тариа тариалах явдлыг дэмжих тариаланчдын хоршоодыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, төрийн бус байгууллагуудыг татан оролцуулна. Тамхийг орлох амьжиргааны эх үүсвэр амжилттай бүрдүүлж чадсан тариаланчдын туршлагыг судалж, мэдээллийг олон нийтэд хүргэхэд анхаарна.
- **Дэмжих үйл ажиллагаа** - зарим улсад үйл ажиллагаа явуулдаг кофе, цайны зөвлөл зэрэг тамхинаас бусад үр тарианы зөвлөлүүд удирдан хэрэгжүүлбэл зохино.

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үйл ажиллагаа нь тариаланчдын тамхи тариалалтаас хараат байдлыг халах аюулгүй арга юм. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах асуудалд онцгой анхаарах шаардлагатай. Үүнд: (а) тамхи тариаланчдын шийдвэр гаргалтын үйл явцыг үнэн зөвөөр ойлгох, (б) тамхийг орлох амьжиргааны эх үүсвэрийн талаарх тариаланчдын ойлголтыг нэмэгдүүлж, хүсэл эрмэлзэл бий болгох, шинэ бүтээгдэхүүний эрэлтийг тогтвортой байлгах ханган нийлүүлэлтийн сүлжээ байгуулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги.

Тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох аргачлалын үндсэн бүрэлдэхүүн хэсгийг Хавсралт 2-т толилуулсан болно.

4.8 Тамхийг орлох амьжиргааны эх үүсвэр бүрдүүлэхийг дэмжих мэдээллийн төв байгуулах

Тамхи тариаланчид болон бусад ажилчдыг амьжиргааны өөр эх үүсвэртэй болгох хэрэгцээ улс орнуудад харилцан адилгүй байдаг. Тамхи тариалдаг улс орнуудад тамхинаас бусад төрлийн үр тариаг ургуулах, боловсруулах, борлуулахтай холбоотой мэдлэг нэгэнт хуримтлагдсан байдаг. Тухайн улсад нэгэнт уламжлалт болсон үр тариаг тариалахад хүндрэлтэй асуудал тэр бүр гардаггүй. Харин био-түлшний ургамал зэрэг шинэ үр тариа тариалахын тулд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, туршлага солилцох, зах зээлийн боломжийг таниулах мэдээллийн төвүүдийг байгуулах шаардлагатай. Эдгээр төвүүд нь нэг ёсны лавлагаа лабораторийн үүрэг гүйцэтгэнэ.

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох нь урт хугацааны зорилт учраас мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааг нэлээд олон жил санхүүжүүлэх эх үүсвэрийг баталгаажуулах хэрэгтэй.

4.9 Иргэний нийгмийн оролцоог хангах

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл ажиллагаанд ДЭМБ-ын ТХСК-ийн зорилтыг дэмждэг өрхийн газар тариалангийн байгууллага болон иргэний нийгмийн бусад байгууллагын үр дүнтэй оролцоог хангах шаардлагатай. Төрийн бус байгууллагууд нь тамхи тариалдаг бүс нутагт тамхийг орлох амьжиргааны эх үүсвэрүүдийг бий болгох төлөвлөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг (Хавсралт 2-оос харна уу).

Тамхи тариалахтай холбоотой эдийн засгийн, байгаль орчны болон нийгмийн далд өртгийн талаарх мэдээллийг түгээх, тамхи үйлдвэрлэгчдийн хууль бус үйл ажиллагааг хянах, илчлэхэд төрийн бус байгууллагууд чухал түнш болж чаддаг. Түүнчлэн тэд тариаланчдад мэргэжил аргазүйн болон бусад дэмжлэг олж авах, өөртөө туслах бүлэг, хоршоо байгуулах, газар тариалангийн экологийн үзэл санааг дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

4.10 Тамхи тариалдаг бүс нутагт нийгмийн, эрүүл мэндийн байгаль орчны хамгааллын үйлчилгээг бэхжүүлэх

- **Тамхи тариалдаг бүс нутагт хүүхдийн хөдөлмөрийг халах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах.** Тамхи тариалахтай холбоотой өрийн боолчлол, хүүхдийн хөдөлмөрийг эрс эсэргүүцэж, боломжтой бол бүрэн халах шаардлагатай. Энэ асуудалд хамааралтай олон улсын хэд хэдэн гэрээ, конвенц бий. Оролцогч талууд ОУХБ-ын Зохистой хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тамхи үйлдвэрлэлийн салбарт хөхиүлэн дэмжиж, ОУХБ-ын холбогдох суурь конвенциуд, 29, 105, 182 дугаар конвенциудыг хэрэгжүүлнэ. Эдгээр нь албадан хөдөлмөрийн бүх хэлбэр, үүн дотроо 18 хүртэлх насны хүүхдүүдийн хөдөлмөрийг хориглодог байна. Оролцогч талууд хараахан хэрэгжүүлээгүй байгаа бол үндэсний хууль тогтоомжоо олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх арга хэмжээ авах шаардлагатай. Мөн газар тариалангийн салбарт хөдөлмөрийн хяналт тавьж, хууль тогтоомж зөрчсөн явдалд хариуцлага ногдуулах арга хэмжээ авах нь зүйтэй. Үүний зэрэгцээ үнэ тогтоох механизмыг судалж, сайжруулах (хамтын хэлэлцээр хийх, гэрээнд ажилчдын эрхийг тусгах) замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой. Нэн ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн мөлжлөгийг устгах талаар хүчин чармайлт гаргах шаардлагатай.

- **Тамхи тариаланчид болон бусад ажилчдын эрүүл мэндийг хамгаалах.** Тамхи тариалахтай холбоотой хор хөнөөлийн талаарх судалгааны тоо мэдээг нэгтгэж, тариаланчид болон бусад сонирхогч талуудад хүргэнэ. Тамхи тариалахтай холбоотой эрсдэлийг таниулах сургалт, сурталчилгааны үр дүнтэй хөтөлбөрийг холбогдох бүх салбарыг оролцуулан боловсруулна.

Энэ зорилтын хүрээнд тамхины ногоон эмгэг, пестицидын хордлого болон тамхи тариалахтай холбоотой бусад эрүүл мэндийн асуудлыг эрт илрүүлэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн ажиллагсдыг сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ. Тамхи тариалахтай холбоотой өвчин, эмгэгийг ажил мэргэжлээс шалтгаалах өвчин, эмгэгийн үндэсний жагсаалт болон ХАА-н аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжид тусгана.

- Тамхи тариалахтай холбоотой хор хөнөөлөөс байгаль орчныг хамгаалах. Оролцогч талууд тамхи тариалдаг бүс нутагт ой модны сүйтгэл, хөрс, усны пестицидын бохирдлыг хянах арга хэмжээ авна. Тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох санаачилгын хүрээнд тамхи тариалахтай холбоотой байгаль орчинд учирч буй хор хөнөөлийг таниулах сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулна. Оролцогч талууд байгаль орчныг хамгаалах үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн тамхи тариалахтай холбоотой байгаль орчны доройтлоос хамгаалах, нэгэнт учирсан хохирлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

5. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх төлөвлөлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Конвенцийн 17 дугаар зүйл нь тамхи тариаланчид, бусад ажилчид, борлуулагч нарт тамхийг орлуулах амьжиргааны тогтвортой эх үүсвэр бүрдүүлж, эдийн засгийн хувьд тамхинаас хараат байдлыг бууруулах, харин 18 дугаар зүйл нь тамхины үйлдвэрлэлтэй холбоотой эрүүл мэндийн болон байгаль орчны хор хөнөөлийг арилгах зорилготой байна.

Аливаа бодлогыг хэрэгжүүлснээр өөрчлөхийг зорьж буй асуудалтай холбоотой суурь нөхцөл байдлыг тодорхойлох, оношлох шаардлагатай байдаг. Мөн тухайн асуудалд хэн, юу өртөж байгааг, сонирхогч талуудын хэрэгцээ, бодлогыг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй саад бэрхшээл, тэдгээрийг даван туулах боломжуудыг тодорхойлох нь чухал юм. Оролцогч талуудын хэрэгжүүлж буй арга хэмжээ нь тулгамдсан асуудалд ямар үр нөлөө үзүүлж байгааг хэрхэн хэмжихийг тодорхойлж, хяналт тавина. Түүнчлэн тухайн бодлого зорилтдоо хүрсэн эсэхийг хянах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох нь чухал юм. Үүний тулд бодлого/хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой асуултад хариулахад шаардлагатай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, ашиглах системтэй арга боловсруулах хэрэгтэй. Конвенцийн 17, 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх талаар гарч буй ахиц дэвшилд хяналт-шинжилгээ хийхдээ дараах асуудлыг анхаарна. Үүнд:

- Нөхцөл байдлын дүн шинжилгээ - суурь үнэлгээ;
- Нөхцөл байдлыг өөрчлөх үйл явц;
- Хүлээгдэж буй үр дүн.

Энэ хэсэгт жишээ болгон хяналт-шинжилгээний зөвхөн болохыг зарим бүрэлдэхүүн хэсгүүдийг толилуулсан анхаарна уу.

5.1 ТХСК-ийн 17 дугаар зүйлийн хэрэгжилт - тамхийг орлох амьжиргааны загвар боловсруулах нь

Тамхи тариалдаг бүс нутагт тодорхой хугацааны дотор амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох (Хавсралт 2-оос харна уу) зорилтыг хэрэгжүүлэхийн тулд сайн чанарын нотолгооны суурь бүрдүүлэх шаардлагатай. Үүний тулд юуны өмнө тухайн бодлогыг хэрэгжүүлснээр шийдвэрлэхийг зорьж буй тулгамдсан асуудлын суурь үнэлгээ хийж, зах зээлийн нөхцөл байдал, орон нутгийн онцлог, амьжиргааг олон янз болгоход учирч болзошгүй төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээллийг олж авна. саад бэрхшээл, боломжуудыг ойлгосны үндсэн дээр стратеги Тамхийг орлох амьжиргааны загвар боловсруулах жишээг дор толилууллаа.

5.1(а) Бодлогын хүрээнд шийдвэрлэх тулгамдсан асуудлуудын суурь үнэлгээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээ (Байдал ямар байна вэ?)	Үйл явц (Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ)	Үр дүн (Хэмжиж болохуйц ахиц дэвшил)
Тамхины үйлдвэрлэлийн эдийн засаг (ашиг, газар ашиглалтын цар хүрээ, тамхи үйлдвэрлэлийн сүлжээний шинж чанар/хөдлөлзүй) - ийг ойлгохын тулд тус улсад ямар мэдээлэл цуглуулж, ямар судалгаа хийгдсэн бэ?	Тамхи болон бусад үр тариа тариалах, ХАА-н бусад үйл ажиллагаа эрхлэхэд ашигладаг газрын бүртгэл, мэдээний сан бүрдүүлэх; Үнэ, үйлдвэрлэлийн сүлжээний шинж чанар зэрэг бүс нутаг тус бүрийн тамхины үйлдвэрлэлийн эдийн засагтай холбоотой мэдээ цуглуулах; Тамхины тариалалтын нийгэм-эдийн засгийн үр нөлөө, үүнд орлого, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээг бүс нутаг тус бүрээр хийж, загвар гаргах;	Тамхи болон бусад үр тариа тариалах, ХАА-н бусад үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж буй талбайн дүн шинжилгээ хийгдсэн байна. Тамхины түүхий эдийн эдийн засгийн цогц мэдээний санг бүс нутаг, тамхины ургамлын төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна. Тамхи үйлдвэрлэлийн сүлжээний зохион байгуулалтын цогц дүн шинжилгээ хийгдсэн байна.
Тус улсын тамхины тариалалттай холбоотой хөдөлмөрийн зах зээлийн мэдээ бий юу?	Тамхи тариалах болон ХАА-н бусад үйл ажиллагаанд оролцож буй хөдөлмөрлөх хүчин болон тариаланчид тамхи үйлдвэрлэлийн сүлжээнээс эдийн засгийн хувьд хэр их хамааралтай болох талаар мэдээ цуглуулах;	Тамхи тариаланчдын тоо, тэдгээрийн тамхи үйлдвэрлэлийн сүлжээнээс эдийн засгийн хувьд хэр их хамааралтай болох талаар тоо мэдээтэй болсон байна.

5.1(б) ТХСК-ийн 17 дугаар зүйлийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулахад ашиглах саад бэрхшээл, боломжуудын дүн шинжилгээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээ (Байдал ямар байна вэ?)	Үйл явц (Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ)	Үр дүн (Хэмжиж болохуйц ахиц дэвшил)
<p>Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үйл ажиллагааг дэмжих зорилгоор үр тарианы болон ХАА-н бусад үйл ажиллагааны эрэлтийн урьдчилсан тооцоолол тус улсад хийгдсэн үү?</p>	<p>Тоо мэдээ цуглуулж, загварчлалын тусламжтай эрэлтийг урьдчилан тооцоолох;</p>	<p>Хүнсний баталгаат байдлыг хангахтай уялдуулан үр тарианы эрэлтийн урьдчилсан тооцоолол хийсэн байна.</p>
<p>Тус улсад тамхины тариалалтыг орлуулах боломжуудын талаар стандарт мэдээллийн багц байдаг уу?</p>	<p>Тариалалтын нөхцөл, уур амьсгалын нөхцөл, ургацын гарц, нэмүү өртгийн сүлжээ, стандарт, зах зээл, үнэ, олон улсын худалдаа болон эдийн засгийн бусад хүчин зүйл, эрүүл мэнд, нийгэм, орчны нөлөөллийг харгалзан тамхины тариалалтыг орлуулах боломжуудыг судлах;</p> <p>Тамхийг орлох үр тарианы эдийн засгийн боломжийг тодорхойлох туршилт хийх;</p> <p>Тамхи тариалдаг бүс нутаг тус бүрээр тамхийг орлох амьжиргааны эх үүсвэрийн нийгэм-эдийн засгийн үр нөлөө(орлого, хөдөлмөрийн зах зээл, эрүүл мэнд, орчинд үзүүлэх нөлөө)-г загварчлал хийж үнэлэх;</p>	<p>Тамхины тариалалтыг орлуулах боломжуудын талаар стандарт мэдээллийн багцтай болсон байна. Тамхины тариалалтыг орлуулах газар тариалангийн болон бусад боломжуудыг хэрэгжүүлэх загвар, үүнд бусад салбар дахь хөдөлмөрлөх хүчний эрэлтийн дүн шинжилгээ хийгдсэн байна.</p>
<p>Тус улсын тамхи тариаланчдын амьжиргааны талаар ойлголтыг сайжруулах, амьжиргааны бусад эх үүсвэр бүрдүүлэхэд учирч буй саад бэрхшээлийн зураглал гаргах судалгаа хийж, мэдээ цуглуулсан уу? (аргазүйн хүрээг Хавсралт 2-оос харна уу)</p>	<p>Тамхины үйлдвэрлэл болон түүнийг орлох үйл ажиллагаанд оролцогч талуудын зураглал гаргах;</p> <p>Тамхи тариаланчид шийдвэр гаргагчид, бусад оролцогч талуудын тамхины тариалалт болон тамхийг орлох үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой итгэл үнэмшил, хандлага, зан үйл, шийдвэр гаргах үйл явцыг судлах;</p> <p>Судалгаа хийх, оролцогч талууд болон бодлогын үр өгөөжийг хүртэх талуудтай зөвлөлдөх замаар хэрэгцээ, саад бэрхшээлийг тодорхойлох;</p>	<p>Тамхи тариаланчдын нийгэм-эдийн засгийн төлөв байдал, шийдвэр гаргалтын үйл явц, тамхины үйлдвэрлэлд оролцогч талуудын хоорондын харилцааны дүн шинжилгээ хийгдсэн байна.</p> <p>Тамхийг орлох амьжиргааны эх үүсвэр бүрдүүлэхийг дэмжих стратеги төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай саад бэрхшээл, боломжуудын талаар дүн шинжилгээ хийгдсэн байна.</p>

Нөхцөл байдлын дүн шинжилгээ (Байдал ямар байна вэ?)	Үйл явц (Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ)	Үр дүн (Хэмжиж болохуйц ахиц дэвшил)
Газар тариаланчид болон газар тариалангийн хөгжлийг дэмжих механизм тус улсад байна уу? Энэ нь тариаланчдад хэр хүртээмжтэй вэ?	<p>Эдгээр механизм нь амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгохыг хэрхэн дэмжиж байгаа/дэмжиж болох талаар мэдээлэл цуглуулах;</p> <p>Эдгээр механизмаар дамжуулж амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох дэмжлэгийг хэдэн хүнд үзүүлсэн талаар тоо мэдээ цуглуулах;</p> <p>Эдгээр механизм болон тэдгээрийг ашиглахад учирч буй саад бэрхшээлийн талаар тамхи тариаланчид болон бусад сонирхогч талуудын мэдлэг, хандлагыг судлах;</p>	Тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны олон янз байдлыг дэмжих ямар механизм байдаг, эдгээрийг тариаланчид хэрхэн ашигладаг, хэдэн хүн үр өгөөжийг нь хүртдэг талаар дүн шинжилгээ хийгдсэн байна.
Тамхи тариалдаг бүс нутагт тамхийг орлох амьжиргааны эх үүсвэр бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх мэдээллийн төвүүд тус улсад байдаг уу?	Мэдээллийн төвүүд нь тамхийг орлох амьжиргааны эх үүсвэр бүрдүүлэхийг хөхиүлэн дэмжих ямар үйл ажиллагаа явуулдаг талаар мэдээлэл цуглуулах;	Тамхи тариалдаг бүс нутаг дахь мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааны талаар тайлан гарсан байна.
<p>Хүнсний баталгаат байдлыг дэмжих үндэсний хөтөлбөр бий юу?</p> <p>Тус хөтөлбөрийн хүрээнд сургууль, эмнэлэг, хорих анги зэрэг байгууллагуудад зориулсан хүнсний ханган нийлүүлэлтийг хийдэг үү?</p>	Хүнсний баталгаат байдлыг дэмжих үндэсний хөтөлбөр, хүнсний худалдан авалтын бодлоготой холбоотой тоо мэдээ цуглуулах;	<p>Хүнсний баталгаат байдлыг дэмжих үндэсний хөтөлбөрийн талаар сүүлийн үеийн мэдээлэлтэй болно.</p> <p>Тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох санаачилгын хүрээнд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авах боломжийн талаар сүүлийн үеийн мэдээлэлтэй болно.</p>
Тамхи үйлдвэрлэгчид газар тариалангийн хөгжлийн бодлогын хүрээнд тамхи тариалантын бодлогод нөлөөлөх боломжтой юу?	<p>ХАА-н бодлогыг тамхи үйлдвэрлэгчдийн нөлөөллөөс хамгаалах арга хэмжээ авах;</p> <p>ДЭМБ-ын ТХСК-ийн 17, 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд тус конвенцийн 5.3 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргийн талаар мэдээлэл түгээх;</p>	ТХСК-ийн 5.3 дугаар зүйл, түүнийг хэрэгжүүлэх удирдамж, үндэслэлийн талаар тамхи тариаланчид болон бусад оролцогч талуудын мэдлэг дээшилсэн байна.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ (Байдал ямар байна вэ?)	Үйл явц (Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ)	Үр дүн (Хэмжиж болохуйц ахиц дэвшил)
Тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үйл ажиллагааг дэмжих үндэсний хөтөлбөр бий юу?	<p>Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үндэсний хөтөлбөр, үндсэн оролцогч талууд, хөтөлбөрийн үр өгөөжийг хүртэгчдийн тоо, тэдгээрийн жилийн төсвийн талаар мэдээлэл цуглуулах;</p> <p>Эдгээр бодлогыг тамхи тариаланчид болон бусад оролцогч талуудад хэрхэн ухуулан таниулдаг талаар мэдээлэл цуглуулах;</p> <p>17 дугаар зүйлийг хэрэгжүүлэх үндэсний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;</p> <p>Үндэсний төлөвлөгөө/ хөтөлбөр/ бодлогыг хөдөөгийн хөгжлийн бодлого, хүнсний баталгаат байдлыг хангах хөтөлбөрийн цөм болгох;</p>	<p>Тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үндэсний хөтөлбөрийн тайлан.</p> <p>Тамхийг орлох үр тариа/ үйл ажиллагаа тариалж/ эрхэлж эхэлсэн тариаланчдын тоо.</p> <p>Тамхи тариаланчид тамхи үйлдвэрлэлийн сүлжээнээс хэр зэрэг хараат болохыг тодорхойлсон байна.</p> <p>Хүний болон хөдөлмөрийн капитал сайжирсан байна.</p> <p>Амьжиргаа, хөдөлмөрийн нөхцөл сайжирсан байна.</p>
Тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үйл ажиллагааг дэмжих үндэсний хөтөлбөр бий юу?	<p>Бодлогыг хэрэгжүүлэх урт хугацааны санхүүжилтийн төлөвлөгөө хэрэгжүүлэх;</p> <p>Тамхи тариаланчдад зориулсан боловсрол олгох болон сургалтын хөтөлбөр боловсруулах;</p> <p>Мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх;</p> <p>ДЭМБ-ын ТХСК-ийн 5.3 дугаар зүйлийн дагуу иргэний нийгмийн оролцоог хангах;</p>	<p>Тамхинаас өөр үр тариа тариалах, бусад үйл ажиллагаа явуулахаар зориулалтыг нь өөрчилсөн талбайн хэмжээ.</p> <p>Боловсрол эзэмшүүлсэн, сургалтад хамруулсан тамхи тариаланчдын болон бусад ажилчдын тоо (мэдлэг дээшилсэн байдал)</p>

5.1(в) ТХСК-ийн 17 дугаар зүйлийн хэрэгжилтийг хянах үр нөлөөний шалгуур үзүүлэлт

- Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратеги, арга хэмжээний үр дүнд тамхийг орлох амьжиргааны өөр эх үүсвэрт бүрэн шилжсэн тамхи тариаланчдын тоо буюу эзлэх хувь;
- Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратеги, арга хэмжээний үр дүнд тамхийг орлох амьжиргааны өөр эх үүсвэрт хэсэгчлэн шилжсэн тамхи тариаланчдын тоо буюу эзлэх хувь;
- Тамхи тариаланчид болон бусад ажилчдын дунд тамхийг орлох амьжиргааны эх үүсвэрийг хөхиүлэн дэмждэг хөтөлбөр, бодлогын тоо;
- Эдгээр арга хэмжээний үр дүнд эдийн засаг, нийгмийн статус өөрчлөгдөж байгааг илтгэх бусад шалгуур үзүүлэлт.

5.2 ТХСК-ийн 18 дугаар зүйлийн хэрэгжилт

ДЭМБ-ын ТХСК-ийн 18 дугаар зүйлд тамхины үйлдвэрлэлтэй холбоотой эрүүл мэндийн болон байгаль орчны нөлөөлөл, нийгмийн асуудлуудыг хөндсөн байна. Оролцогч талууд тамхи тариалахтай холбоотой орчны нөлөөллийн аудит хийх стандарт аргачлал боловсруулж, тамхи тариалдаг бүх улс орнуудад ашиглан, хэрэгжүүлэх шаардлагатай зохистой арга хэмжээнүүдийг тодорхойлно. Тамхи тариалдаг бүс нутгуудад мэдээллийн төвүүдийг байгуулж, байгаль орчин, хүний эрүүл мэнд, эдийн засгийн байдалд тамхины үзүүлэх нөлөөллийг таниулна. Тамхины тариалалтын сөрөг нөлөөлөлд өртсөн бүс нутгуудад ой моджуулах зэрэг нөхөн сэргээлтийг хөхиүлэн дэмжинэ. Тамхины ногоон эмгэг зэрэг тамхины тариалалттай холбоотой өвчин, эмгэгийн тархалтын суурь түвшинг тогтоож, конвенцийн 18 дугаар зүйлийг хэрэгжүүлснээр энэ чиглэлд гарч буй ахиц дэвшлийг хянана. Тамхийг орлох амьжиргааны эх үүсвэрийн хувьд мөн орчны нөлөөллийн үнэлгээ хийж, сөрөг нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээ авна.

Дээрх зорилтуудыг хангахын тулд 18 дугаар зүйлийг хэрэгжүүлснээр шийдвэрлэхийг зорьж буй асуудлуудын суурь нөхцөл байдал, тухайн бодлогыг хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээл, боломжуудын дүн шинжилгээг юуны өмнө хийх шаардлагатай. ДЭМБ-ын ТХСК-ийн 17 ба 18 дугаар зүйлийг хамт хэрэгжүүлснээр амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох талаар илүү ахиц дэвшил гаргах боломжтойг анхаарах нь зүйтэй. Тамхины тариалалт болон амьжиргааны бусад эх үүсвэртэй холбоотой эрүүл мэндийн нөлөөллийн талаарх тоо мэдээ болон байгаль орчны аудитын дүн зэргийг олон улсын мэдээний санд тусгах арга хэмжээ авна. ТХСК-ийн 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх жишээг дор толилууллаа.

5.2(а) Шийдвэрлэхийг зорьж буй тулгамдсан асуудлын суурь судалгаа

Нөхцөл байдлын дүн шинжилгээ (Байдал ямар байна вэ?)	Үйл явц (Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ)	Үр дүн (Хэмжиж болохуйц ахиц дэвшил)
Тус улсад тамхины тариалалттай холбоотой эрүүл мэндийн нөлөөллийн судалгаа хийгдсэн үү?	Тамхины тариалалт тариаланчдын эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа талаар тоо мэдээ, мэдээлэл цуглуулах, судалгаа хийх;	Тамхины ногоон эмгэг болон тамхины тариалалттай холбоотой бусад эмгэгийн тархалтын тоо мэдээ. Тамхи тариаланчдын дунд хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээний талаарх тоо мэдээ.
Тамхийг орлох амьжиргааны бусад эх үүсвэрийн орчны нөлөөллийг судалсан уу? Тус улс дахь тамхины тариалалтын нийгмийн үр нөлөөний талаар тоо мэдээ, мэдээлэл бий юу?	Тамхийг орлох үр тарианы бордооны хэрэгцээ, пестицид хэрэглэх шаардлага, ой мод сүйтгэхэд үзүүлэх нөлөөг тамхитай харьцуулж загварчлал гаргах; Тамхи тариалахтай холбоотой хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөлийн талаар тоо мэдээ цуглуулах;	Тамхийг орлох амьжиргааны эх үүсвэрийн орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэнэ. Тамхи тариалахтай холбоотой хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөлийн талаар тоо мэдээтэй болно.

5.2(б) ТХСК-ийн 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулахад ашиглах саад бэрхшээл, боломжуудын дүн шинжилгээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээ (Байдал ямар байна вэ?)	Үйл явц (Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ)	Үр дүн (Хэмжиж болохуйц ахиц дэвшил)
Тамхи тариалах, үйлдвэрлэхтэй холбоотой эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр, бодлого бий юу?	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр, бодлогын хүрээнд тамхины ногоон эмгэг болон тамхины тариалалттай холбоотой бусад эрсдэлийг удирдах үндэсний санаачилгын талаар мэдээлэл цуглуулах;</p> <p>Тамхи тариалахтай холбоотой хор уршгийн талаар тариаланчдад боловсрол олгох;</p> <p>Тамхины ногоон эмгэг болон тамхины тариалалттай холбоотой бусад эрсдэлийг бууруулах асуудлыг хөдөлмөрийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр, бодлогод тусгахыг хөхиүлэн дэмжих;</p>	<p>Тамхины ногоон эмгэг болон тамхины тариалалттай холбоотой бусад эрсдэлийг бууруулах асуудлыг хөдөлмөрийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр, бодлогод тусгасан байна.</p> <p>Тамхи тариалахтай холбоотой эрүүл мэндийн эрсдэлийн тухай мэдлэг, хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ тамхи тариаланчид болон бусад ажилчдын дунд сайжирсан байна.</p> <p>Тамхины ногоон эмгэг болон тамхины тариалалттай холбоотой бусад хор уршгийн тархалт буурна.</p>
Тамхины үйлдвэрлэлийн салбарт үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж шалгадаг уу?	<p>Тамхины үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шалгалт хийх;</p> <p>Тамхи үйлдвэрлэгчдийн хууль бус ажиллагааг илрүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах;</p>	Тамхины үйлдвэрлэлийн сүлжээнд хөдөлмөрийн гэрээний болон хөдөлмөрлөх нөхцөл сайжирсан байна.
Тамхи тариалахад ашиглахыг зөвшөөрсөн пестицидын жагсаалт тус улсад байдаг уу?	<p>Байгаль орчны болон хор судлалын эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан тамхи тариалахад ашиглахыг зөвшөөрсөн пестицидын жагсаалт гаргах;</p> <p>Жагсаалт нь байгаль орчны болон хор судлалын эрсдэлийн хамгийн сүүлийн үеийн үнэлгээнд нийцсэн эсэхийг шалгах;</p>	Тамхи тариалахад ашиглахыг зөвшөөрсөн пестицидын жагсаалт нь байгаль орчны болон хор судлалын эрсдэлийн хамгийн сүүлийн үеийн үнэлгээнд тулгуурласан байх тул орчны сөрөг нөлөөлөл багасна.
Хөрс, усан дахь пестицид, бордооны бохирдлыг хянах систем тус улсад бүрдсэн үү?	Тамхи тариалдаг бүс нутагт бохирдлыг судалж, тамхи тариалдаггүй бүс нутагтай харьцуулах;	Тамхины тариалалттай холбоотой хөрс, усны бохирдлын дүн шинжилгээ хийгдсэн байна.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ (Байдал ямар байна вэ?)	Үйл явц (Асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай арга хэмжээ)	Үр дүн (Хэмжиж болохуйц ахиц дэвшил)
Ой мод сүйдэхэд тамхины тариалалт хэрхэн нөлөөлж байгааг судалсан уу?	Ой мод сүйдэхэд тамхины тариалалт хэрхэн нөлөөлж байгаа талаар тоо мэдээ цуглуулах;	Тамхины тариалалтын ой мод сүйдэхэд үзүүлж буй нөлөөний дүн шинжилгээ хийгдсэн байна.
Байгаль орчныг хамгаалах үндэсний хөтөлбөр, бодлого, хууль бий юу?	Байгаль орчны аудит хийж, доройтлыг бууруулах үндэсний санаачилга, хууль тогтоомжийн талаар мэдээлэл цуглуулах; Үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны аудит хийж, доройтлыг бууруулах газар нутгийн жагсаалтад тамхины газар тариалангийн бүс нутгийг хамруулахыг хөхиүлэн дэмжих.	Ой мод, ус, хөрсний бохирдол, үр тариан дахь пестицидын үлдэгдэл, хүнд металын бохирдлыг бууруулах хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогод тамхины тариалалтын аудитын асуудлыг тусгасан байна. Тамхи тариалдаг бүс нутагт ой мод болон байгалийн бусад нөөцийн нөхцөл байдал сайжирна.

5.2(в) ТХСК-ийн 18 дугаар зүйлийн хэрэгжилтийг хянах үр нөлөөний шалгуур үзүүлэлт

1. Тамхи тариалдаг бүс нутаг дахь тамхины ногоон эмгэг, пестицидын хордлого зэрэг тамхи тариалахтай холбоотой бусад хор уршгийн тархалт;
2. Тамхи тариалдаг бүс нутаг дахь хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо буюу эзлэх хувь;
3. Тамхи болон тамхийг орлуулах үр тариа тариалдаг бүс нутаг дахь сүйдсэн ой модны эзлэх хувь.

6. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ДЭМБ-ын ТХСК-ийн Оролцогч талууд олон улсын хамтын ажиллагаатай холбоотой олон чухал амлалт авсан нь тус конвенцийн 4 дүгээр зүйл (*Үндсэн зарчим*), 5 дугаар зүйл (*Нийтлэг эрх, үүрэг*), 19 дүгээр зүйл (*Хариуцлага*), 20 дугаар зүйл (*Эрдэм шинжилгээ, тандалт, мэдээлэл солилцох*), 21 дүгээр зүйл (*Тайлагнах ба мэдээлэл солилцох*), 22 дугаар зүйл (*Шинжлэх ухааны, мэргэжлийн болон хууль эрхзүйн салбарт хамтран ажиллах, мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэх*), 26 дугаар зүйл (*Санхүүгийн нөөц*)-д туссан байна.

Олон улсын хамтын ажиллагаанд мөн "Бидний хүсч буй ирээдүй" хэмээх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн A/RES/66/288 дугаар тогтоолын заалтуудыг мөрдлөг болгоно.

Олон улсын хамтын ажиллагаа нь ДЭМБ-ын ТХСК-иар хүлээсэн үүргийн хүрээнд дараах асуудлуудад анхаарвал зохино. Үүнд:

6.1 Тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд эдийн засгийн тогтвортой амьжиргааг дэмжих, зах зээлийг хөгжүүлэх

Оролцогч талууд эдийн засгийн тогтвортой амьжиргааг хөхиүлэн дэмжих зорилгоор туршлага, мэдээлэл солилцоно. Түүнчлэн эрэлт, нийлүүлэлт, үүнд мөн тамхийг орлох үр тарианы зах зээлийн хэрэгцээ шаардлагыг ойлгохын тулд дотоодын бүс нутгийн болон дэлхийн зах зээлийн тоглогчидтой харилцаа холбоо тогтоох хүчин чармайлт гаргана. Тамхийг орлох үр тариа нь байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хангах зорилтод нийцсэн байх шаардлагатай.

6.2 Үндэсний, бүсийн болон олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллах

Оролцогч талууд үндэсний, бүсийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ДЭМБ-ын ТХСК-ийн 5.3 дугаар зүйлийн дагуу тамхины үйлдвэрлэлийг дэмжихгүй байх арга хэмжээ авна. Олон улсын хамтын ажиллагаа нь тамхийг орлох амьжиргааны эх үүсвэр бүрдүүлэх, ХАА-н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний баталгаат байдлыг хангах дэлхий нийтийн хүчин чармайлтыг дэмжихэд чиглэнэ.

Санал болгож буй арга хэмжээ:

1. Бүсийн болон олон улсын байгууллагууд тамхи тариалдаг улс орнуудад тамхийг орлох амьжиргааны эх үүсвэр бий болгоход нь хүсэлтийнх нь дагуу өөрийн мандатын хүрээнд дэмжлэг үзүүлж, хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх дэлхий нийтийн хүчин чармайлттай нэгтгэх;
2. Бүсийн болон олон улсын байгууллагууд тамхи тариалдаг улс орнуудад хөдөлмөр, байгаль орчин, эрүүл мэнд, хүний эрхтэй холбоотой олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг бэхжүүлэхэд хүсэлтийнх нь дагуу өөрийн мандатын хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

6.3 Чадавх бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах

Оролцогч талууд сургалт зохион байгуулах, мэргэжил аргазүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр өөр хоорондоо шууд буюу эрх бүхий олон улсын байгууллагаар дамжуулж хамтран ажиллана. Мөн шинжлэх ухааны, мэргэжлийн, технологийн асуудлаар, үүнд тамхийг орлох амьжиргааны эх үүсвэр бүрдүүлэх зохистой технологи, туршлага солилцох чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлнэ. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан, Дэлхийн банк, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал, ОУХБ зэрэг энэ чиглэлээр мэргэшсэн нь хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын байгууллагууд тамхийг орлох амьжиргааны тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх чадавх бэхжүүлэхэд оролцох нь чухал юм. Оролцогч талууд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын байгууллагуудаас дэмжлэг хүсэх боломжтой.

Оролцогч талууд шинжлэх ухааны, мэргэжлийн, технологийн асуудлаар сургалт, мэргэжил аргазүйн дэмжлэг, хамтын хүчин чармайлтыг дэмжих зорилгоор хоёр ба олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж, ингэхдээ хөгжиж буй болон шилжилтийн эдийн засаг бүхий Оролцогч талуудын хэрэгцээг харгалзан үзэх нь зүйтэй. Хамтын ажиллагааг хөгжүүлэхэд санхүүгийн нөөц амин эх үүсвэр бүрдүүлэхэд засгийн газрууд тамхины нийт татварын чухал юм. Өнөөг хүртэл

тамхины тариалалтыг орлох амьжиргааны орлогын 0.5-аас бага хувийг зориулж ирснийг харгалзан Оролцогч талууд энэ чиглэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжинэ.

Санал болгож буй арга хэмжээ: Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн 26 дугаар зүйл (*Санхүүгийн нөөц*)-д санал болгосон арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

6.4 Олон улсын мэдээллийн солилцоо

Оролцогч талууд холбогдох олон улсын байгууллага болон Конвенцийн нарийн бичгийн даргын газартай хамтран тамхийг орлох тогтвортой амьжиргааны эх үүсвэр болон тамхины ургамлын эрэлтийн тухай мэдээллийг солилцох систем байгуулж, хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү мэдээлэл нь Оролцогч талуудын гаргаж өгсөн албан ёсны мэдээлэл болон олон улсын байгууллагын мэдээлэл байх ба мэдээллийн солилцоог Конвенцийн нарийн бичгийн даргын газар уялдуулан зохицуулна. Улмаар улс орнуудын шилдэг туршлагын мэдээний сан бүрдүүлж, улс орнуудад нэг нэгнийхээ туршлагаас суралцах боломж олгоно. Оролцогч талууд ДЭМБ-ын ТХСК-ийн тайлагналтын механизмыг ашиглан конвенцийн 17, 18 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар тогтсон хугацаанд мэдээлэх ёстой.

Хүлээгдэж буй үр дүн: Оролцогч талуудын ирүүлсэн хэрэгжилтийн тайланд туссан тус конвенцийн 17, 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэх шилдэг туршлагын талаарх мэдээллийг бүх Оролцогч талуудад хүртээмжтэй болгоно.²⁶

6.5 Олон улсын хамтын ажиллагаа ба Конвенцийн нарийн бичгийн даргын газрын үүрэг

Конвенцийн нарийн бичгийн даргын газар нь Оролцогч талууд, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулж, конвенцийн 17, 18 дугаар зүйлийн үр дүнтэй хэрэгжилтийг хангана. Конвенцийн нарийн бичгийн даргын газар нь НҮБ-ын ХХААБ зэрэг энэ чиглэлээр мэргэшсэн олон улсын байгууллагуудыг Оролцогч талуудын Бага хурлаас байгуулсан ажлын хэсэг буюу засгийн газар хоорондын бусад механизмын үйл ажиллагаанд урьж оролцуулна. Конвенцийн нарийн бичгийн даргын газар нь тамхийг орлох үр тарианы судалгааг дэлхийн, бүсийн, улс хоорондын түвшинд хийж гүйцэтгэж буй НҮБ-ын ХХААБ болон олон улсын бусад байгууллагатай хамтран дэлхийн өнцөг булан бүрт холбогдох байгууллага, сүлжээтэй хамтран ажиллана. Конвенцийн нарийн бичгийн даргын газар нь Оролцогч талуудын гаргаж өгсөн албан ёсны болон олон улсын байгууллагын мэдээлэлд тулгуурлан мэдээлэл солилцох үйл ажиллагааг уялдуулан зохицуулна. Конвенцийн нарийн бичгийн даргын газар нь 17, 18 дугаар зүйлийн системтэй хэрэгжилтийг хангахад сонирхсон Оролцогч талууд болон холбогдох байгууллага, сүлжээг татан оролцуулна.

²⁶ Мэдээний санг <https://fctc.who.int/who-fctc/reporting/implementation-database> вэбсайтаас харна уу.

ХАВСРАЛТ 1

ТАМХИНЫ ТАРИАЛАЛТЫГ ОРЛОХ ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ЭХ ҮҮСВЭРТЭЙ ХОЛБООТОЙ НЭР ТОМЪЁОНЫ ЖАГСААЛТ

- **Тариалалтын систем:**^{1,2} Газар тариалан эрхлэгч үр тариаг хэрхэн ургуулдгийг тайлбарласан ойлголт. Тариалалтын дараах систем байдаг: ээлжлэн тариалах, нэг улиралд хоёр ба түүнээс дээш үр тариаг нэг талбайд тариалах, холимог тариалалт, зурвасаар сөөлжлөн тариалах;
- **Нэр төрлийг нэмэгдүүлэх:** Нэг үр тарианаас хараат байдлыг бууруулах, ган буюу үерийн улмаас ургац алдах зэрэг хэврэг байдлыг багасгах, орлого улирлын чанартай жилийн турш хэлбэлзэхийг багасгах стратеги хэрэгжүүлэх;
- **Эдийн засгийн тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх:** Хүний хэрэгцээг хангахын зэрэгцээ байгаль орчныг хамгаалахыг зорьж, одоогийн төдийгүй дараа дараагийн үеийн хэрэгцээг хангах;
- **Байгаль орчны аудит:**²⁷ Байгаль орчны менежментийн хөтөлбөрийн үр дүнг баталгаажуулах; байгаль орчныг хамгаалах зорилтын хэрэгжилтийг хангах; ирээдүйд бизнесийг өргөжүүлэх, байгаль орчны хууль тогтоомж өөрчлөгдөх, байгаль орчны шинэ тулгамдсан асуудал гарахад байгаль орчны менежментийн системийг хэрхэн өөрчилж, хөгжүүлэх шаардлагатайг үнэлэх үйл явц;
- **Орчны нөлөөллийн үнэлгээ:**²⁸ Аливаа үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөний үнэлгээ;
- **Орчны хяналт-шинжилгээ:** Байгаль орчны чанарын өөрчлөлтийг тодорхой байршилд тасралтгүй үнэлэх ажиллагаа;
- **Орчны нөхөн сэргээлт:** Экологийн эвдрэл илаарших үйл явцыг эрчимжүүлэх зориудын хүчин чармайлт;
- **Навчны компани буюу анхан шатны боловсруулагч:** Тариаланчдаас тамхины түүхий эдийг худалдан авч, тамхины навчинд эхний боловсруулалт хийж, тамхины түүхийн эдийг зэрэглэлд ангилдаг худалдан авагч;
- **Хүнсний баталгаат байдал:**²⁹ Хүнсний хүн амд хүртээмжтэй байдал;
- **Газар тариалангийн зохистой дадал:**³⁰ ХАА-н бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, байгаль орчин болон нийгэмд ээлтэй аргаар үйлдвэрлэх дадал;
- **Тамхины ногоон эмгэг:** Тамхины ургамлыг ургуулах, үед түүнтэй хүрэлцсэнээс никотин хураах арьсаар шимэгдэж, никотины хордлого үүсэх. Никотин нь тамхины ногоон навчин дээрх усанд уусдаг ус ба тосонд уусамтгай алкалоид юм.³¹;

²⁷ Эх сурвалж: НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр

²⁸ Эх сурвалж: НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр

²⁹ Trade reforms and food security. Rome: Food and Agriculture Organization of the United Nations; 2003.

³⁰ World programme for the census of agriculture: A system of integrated agricultural censuses and surveys (FAO Statistical Development Series). Rome: Food and Agriculture Organization of the United Nations; 2005.

³¹ Arcury TA, Quandt SA. Health and social impacts of tobacco production. Journal of Agromedicine. 2006;11:71-81.

- **Хүний капитал:** Хөдөлмөрлөж, эдийн засгийн өртөг бий болгох чадвараар илэрдэг мэдлэг, ур чадвар, хувь хүний зан чанарын нийлбэр; боловсрол эзэмших, туршлага хуримтлуулах замаар бий болдог бие хүний шинж чанар;
- **Орчинд үзүүлэх нөлөө:**³² Хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, амьтны аймаг, ургамлын аймаг, хөрс, агаар, ус, уур амьсгал, газрын гадаргуу, түүхийн дурсгалт зүйл, бусад биет бүтэц зэрэг орчинд тухайн үйл ажиллагааны үзүүлэх аливаа нөлөө буюу эдгээр хүчин зүйлийн харилцан үйлчлэл; мөн эдгээр хүчин зүйлийг өөрчилснөөс соёлын өв буюу нийгэм-эдийн засгийн нөхцөл байдалд үзүүлэх нөлөө;
- **Хувь хүний чадавх:** Хувь хүн өөртөө хөгжлийн зорилт тавьж, түүндээ хүрэх ур чадвараа бэхжүүлэх, хадгалах үйл явц;
- **Сөөлжлөн тариалах:** Хоёр буюу түүнээс олон төрлийн үр тариаг нэг нэгнийх нь ойролцоо тариалах. Энэ нь нэг төрлийн үр тарианы ашиглахгүй шим тэжээлийг бүрэн ашиглаж, нэгж талбайгаас хураах ургацын хэмжээг нэмэгдүүлэх зорилготой.
- **Зурвасаар сөөлжлөн тариалах:** Нэг зурваст нэг төрлийн үр тариа суулгаж, хажуугийн зурваст өөр төрлийн үр тариа суулгах арга;
- **Ээлжлэн тариалах:** Нэг талбайд өөр өөр улиралд өөр өөр төрлийн үр тариа тариалах арга. Энэ нь хөрсөнд ашигтай бөгөөд үр тариа тариалсны дараах улиралд ногоон бордуур тариалж, хөрсөн дэх азотыг нөхөх арга юм. Нэг төрлийн үр тариаг дагнан тариалахад шавж болон эмгэг төрөгчид хуримтлагддаг тул ээлжлэн тариалах замаар ийнхүү хуримтлагдахыг багасгах боломжтой юм. Мөн гүн үндэстэй ургамлыг өнгөц үндэстэй ургамалтай ээлжлэн тариалах замаар хөрсний бүтцийг сайжруулж болдог.
- **Салбар хоорондын хамтын ажиллагаа:** Нийгмийн болон эдийн засгийн өөр өөр салбар, байгууллагуудтай хамтран ажиллах;
- **Амьжиргааны эх үүсвэр:** Хөдөөгийн айл өрхүүд амь зуулгаа залгуулж, амьдрах нөхцөлөө сайжруулахын тулд явуулж буй үйл ажиллагаа, авч буй нийгмийн дэмжлэгийн цогц;
- **Үйлдвэрлэлийн сүлжээ:** Орцыг гарц (бүтээгдэхүүн) болгон хувиргах тогтолцоо. Үйлдвэрлэлийн сүлжээний орц нь хүний нөөц, газар, тоног төхөөрөмж, барилга байгууламж, технологи, харин гарц нь үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн гарт хүргэж буй бараа, үйлчилгээ байна.
- **Тамхины тариалалт:** Гэрээний буюу гэрээний бус үндсэн дээр зарах зорилгоор *Nicotiana tabacum* болон *Nicotiana rustica* ургамлыг тариалах;
- **Тамхи үйлдвэрлэгч:**³³ Тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, бөөний дистрибьютер, импортлогч;
- **Тамхин бүтээгдэхүүн:**³⁴ Тамхины навчийг түүхий эд болгон ашиглаж, уушгилах, зажлах, хамраар татах зориулалтаар ашигладаг бүтээгдэхүүн;
- **Тамхины салбарын ажилчин:** Тамхины ферм, тамхины боловсруулалт хийх компани, тамхины үйлдвэрт тухайн улсын хөдөлмөрийн хуулийн дагуу гэрээний буюу гэрээний бус үндсэн дээр ажиллаж буй хүн.

³² Эх сурвалж: НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр

³³ ДЭМБ-ын ТХСК-аас тодорхойлолтыг авав.

³⁴ ДЭМБ-ын ТХСК-аас тодорхойлолтыг авав.

ХАВСРАЛТ 2

ТАМХИ ТАРИАЛДАГ БҮС НУТАГТ АМЬЖИРГААНЫ ЭХ ҮҮСВЭРИЙГ ОЛОН ЯНЗ БОЛГОХ АРГАЧЛАЛ

1. ТАНИЛЦУУЛГА

Энэ хавсралтад тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох зорилгоор авах арга хэмжээ, тэдгээрийн дэс дарааллыг толилуулсан болно. Уг аргачлал нь тариаланчид өөрсдийн хүссэн, сэтгэл санаанд нь нийцсэн аргаар амьжиргаагаа залгуулах эрх чөлөөтэй байх, энэхүү эрх чөлөөг нь нийгмийн бодлогоор дэмжих, үйлдвэрлэлийн сүлжээг амжилттай өөрчлөхийн тулд нийгмийн болон эдийн засгийн холбогдох тоглогчдыг идэвхтэй оролцуулах үзэл санаанд тулгуурладаг.

2. АРГАЗҮЙН УДИРДАМЖ

2.1 доороос дээш чиглэсэн аргачлал

Тамхинаас өөр амьжиргааны эх үүсвэртэй болох эсэх шийдвэрийг тариаланчид өөрсдөө гаргах тул энэ талаар хэрэгжүүлэх стратегийг тодорхойлоход тэднийг оролцуулахгүйгээр амжилтад хүрэх боломжгүй юм.

2.2 Оролцогч талуудын сүлжээ

Газар тариалан бол нийгмийн үйлдвэрлэлийн тусгаарлагдсан үзэгдэл биш, харин ханган нийлүүлэлтийн сүлжээ болон орон нутгийн компаниудын эргэн тойронд төвлөрсөн өөр өөр боловч хоорондоо харилцан хамааралтай нийгмийн тоглогч нарын оролцоотой үзэгдэл юм. Иймд амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үйл явц ч гэсэн тариаланчдаас гадна ижил төстэй сонирхол бүхий бусад олон этгээдийн оролцоонд тулгуурлах бөгөөд тэдгээр нь үйлдвэрлэлийн шинэ сүлжээ, маркетингийн шинэ суваг бүрдүүлэхэд оролцох боломжтой юм.

2.3 Өөр өөр түвшний (орон нутгийн, бүсийн ба үндэсний) засаг захиргааны интеграцчилал

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгоход бүх түвшний засаг захиргааны дэмжлэгт бодлого, үйл ажиллагаа болон нөөцийг дайчилж илүү үр дүнд хүрэх хамтын хүчин чармайлт шаардлагатай юм.

2.4 Оролцоонд тулгуурласан төлөвлөлт ба хэрэгжилт

Энэхүү үйл явцын амжилт нь холбогдох нийгэм-эдийн засгийн хүчин зүйл болон тоглогч нарын идэвхтэй оролцооноос хамаардаг. Иймд төлөвлөсөн стратегийг хэрэгжүүлэх талуудыг бүх сонирхогч талуудын оролцоотойгоор эрэмбэлж сонгосны үндсэн дээр хэрэгжилтийг эхлүүлнэ.

2.5 Нутаг дэвсгэрийн хандлага

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгохдоо ХАА-н бүтээгдэхүүнүүд өөрийн гэсэн үйлдвэрлэл, хэрэглээний сүлжээтэй ба энэ нь тухайн орон нутгийн хил хязгаарт баригддаггүй болохыг анхаарах нь зүйтэй. Иймд нөөцийн хуваарилалт, үйлдвэрлэлийн цар хүрээ, дэд бүтэц, түгээлт, бүтээгдэхүүний зах зээлийг бүсчилж хөгжүүлэх нь бүх шаардлагатай нөөцийг дайчлах боломж олгодог байна.

2.6 Тасралтгүй хяналт-шинжилгээ, үнэлгээ

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратеги нь сонирхогч талуудын оролцоог хэр сайн хангаснаас хамаарах бөгөөд энэ нь нийгмийн бодлоготой салшгүй холбоотой байдаг. Иймд өөр өөр үүрэг хариуцлага, ашиг сонирхолтой талуудын оролцоог хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, үйл ажиллагаанд шаардлагын дагуу тохируулга хийх нь чухал юм.

3. ҮЙЛ ЯВЦЫГ ЭХЛҮҮЛЭХ НЬ: АРГА ХЭМЖЭЭНИЙ ГИНЖИН ХЭЛХЭЭ

3.1 Анхаарлыг нэг чигт хандуулах

Оролцоонд тулгуурласан төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ нь энэхүү аргачлалын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болдог тул амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох зорилго, стратегийг оролцогч талуудад эхнээс нь сайтар ойлгуулж, нэгдмэл ашиг сонирхол бий болгох нь чухал юм.

Иймд хэвлэл мэдээллийн хэрэгсэл (радио, телевиз, сонин г.м.)-ээр мэдээлэл түгээх, иргэний нийгмийн байгууллага болон ферм дээр очиж ажиллах замаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай. Ер нь, олон нийтийн цуглаан, иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн засаг захиргаатай уулзалт зохион байгуулж, хэлэлцүүлэг, яриа өрнүүлэх нь чухал байдаг. Сонирхогч талуудад мэдээлэл хүргэж, ерөнхий зарчмууд дээр зөвшилцөлд хүрсэн тохиолдолд үйл ажиллагааны болон хяналт-шинжилгээний нэгдсэн төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.

3.2 Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох зорилтыг хэрэгжүүлэхийн тулд зорилго, шаардагдах нөөц, хариуцах эзэн, хугацаа зэргийг тогтооход тус дөхөм болох мэдээлэл цуглуулна. Иймд тамхины газар тариалангийн тогтолцоонд дүн шинжилгээ хийхээс төлөвлөлтийг эхлүүлнэ. Улмаар тариаланчдын хэтийн төлөвлөгөө, тэдэнд тулгарч буй саад бэрхшээл, боломж, тамхины тариалалтын чиг хандлага зэргийг харгалзан тариаланчдын шийдвэр гаргах үйл явцын дүн шинжилгээ хийнэ.

Ингэхдээ тариаланчид үйлдвэрлэлийн арга хэрэгслийн хүртээмж, үр тарианы ашигтай байдал зэрэг объектив хучин зүйлээс гадна субъектив болон нийгмийн хүчин зүйлийг харгалзан ямар үйлдвэрлэлийн сүлжээ ашиглах талаар шийдвэр гаргадаг болохыг анхаарах нь зүйтэй.

Дүн шинжилгээг асуумж судалгааны тусламжтай хийж болохоос гадна дараах хүчин зүйлийн нөлөөг тодруулах нөлөөллийн үнэлгээ хийж болно. Үүнд:

- Өрхийн бүтэц;
- Байгалийн нөөцийн хүртээмж;
- Үйлдвэрлэлийн арга хэрэгслийн хүртээмж;
- Өрхийн эрхэлж буй тамхинаас бусад газар тариалангийн болон мал аж ахуйн үйлдвэрлэл;
- Амь зуулга залгуулах бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
- Тамхинаас бусад бүтээгдэхүүний маркетингаас олдог орлого;
- Тамхины үйлдвэрлэлийн сүлжээ ба санхүүгийн гүйцэтгэл;
- Үйлчилгээний хүртээмж ба нийгмийн бодлого;
- Зээл, банкны бусад үйлчилгээний хүртээмж;
- Нийгмийн оролцоо;
- Эдийн засгийн ба нийгмийн түншүүд;
- Өрхийн болон олон нийтийн үнэт зүйл, тэргүүлэх чиглэл;
- Эрүүл мэндийн байдал, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин;
- Өнөөгийн нөхцөл байдалд сэтгэл ханамж;
- Өмчтэй холбоотой төлөвлөгөө.

3.3 Мэдээллийн солилцоо ба оролцоонд тулгуурласан төлөвлөлт

Асуумж судалгаа болон уулзалтуудаас цуглуулсан тоо мэдээнд дүн шинжилгээ хийж, дараах мэдээг сонирхогч талуудад хүргэнэ. Үүнд:

- нөхцөл байдлын дүн шинжилгээ;
- тэргүүлэх чиглэл;
- стратеги ба үйл ажиллагаа;
- зорилго ба хэрэгжүүлэх хугацаа;
- санхүүжилтийн эх үүсвэр;
- нийгмийн бодлогын хүрээ;
- үүрэг, хариуцлага;
- хяналт-шинжилгээ, үнэлгээ, дахин төлөвлөлтийн үйл явц.

3.4 Оролцоонд тулгуурласан хэрэгжилт

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох орон нутгийн төлөвлөлтийн удирдах зөвлөл байгуулж, эрх бүхий албан тушаалтнууд болон нийгмийн бусад талуудыг нэгтгэсэн хамтын ажиллагааны сүлжээ, түншлэл байгуулна.

Амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгоход сонирхогч талуудын оролцоо ил тод, нээлттэй байх шаардлагатай. Сонирхогч талуудын оролцоог баталгаажуулахын тулд холбогдох мэдээллээр хангаж, хөшүүрэг бий болгоно.

Нийгмийн ажилтан, тариаланчдыг сургалтад хамруулж, нийгмийн идэвхтэй оролцоог хангах замаар амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үйл явцыг эрчимжүүлж, улмаар төрөөс дэмжлэг авахад чухал хувь нэмэр оруулдаг байна.

3.5 Тасралтгүй хяналт-шинжилгээ, дүн шинжилгээ, үнэлгээ, үйл ажиллагааны шинэ мөчлөгийн эхлэл

Тамхи тариалдаг бүс нутагт амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох үйл явцыг удирдан зохицуулж, хяналт-шинжилгээ хийх чиг үүрэг бүхий удирдах зөвлөл байгуулна. Хяналт-шинжилгээ хийхдээ үр дүнг үнэлэх, дахин төлөвлөлт хийх олон нийтийн цуврал уулзалтуудыг зохион байгуулах хэлбэрээр сонирхогч талуудын оролцоог хангаж, нэгдсэн зохицуулалтаар хангана. Нийгмийн оролцоо, олон нийтийн өмчлөл, мэдээллийн ил тод байдлыг чухалчилах нь амьжиргааны эх үүсвэрийг олон янз болгох стратегийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй.

-oOo-